

# ХОТЫН ЗАХЫН ХОРООЛЛЫН НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ: БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТ Судалгааны тайлан

2010 оны кейс судалгаа, 2011 оны давтан судалгааны үр дүнгээр  
боловсруулав

Бэлтгэсэн: Т.Амгалан  
Б.Онон  
Н.Баясгалан  
Н.Эрдэнэсүвд

Энэхүү судалгааг Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр Зохистой Хөгжлийн Жендэр Төв болон түүний дэргэдэх Нутгийн хөгжлийн төв хамтран гүйцэтгэв.

Байгууллагын мэдээлэл:

**Зохистой Хөгжлийн Жендэр Төв**

Зохистой Хөгжлийн Жендэр Төв нь 1995 онд байгуулагдсан, аливаа улс төрийн нам эвслээс хараат бус, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага бөгөөд эрхэм зорилго нь Монгол хүний хөгжлийг тал бүрээр дэмжиж, улс орны зохистой хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход хувь нэмэр оруулахад оршдог.

Хаяг: Улаанбаатар хот, Шуудангийн 38-р салбар

Чингэлтэй дүүрэг, Дипломат -95-р корпус, 73 тоот

Утас/Факс: 976-11-325627

Электрон шуудан: [wirc@magicnet.mn](mailto:wirc@magicnet.mn)

**Нутгийн Хөгжлийн Төв**

Нутгийн Хөгжлийн төв нь 2004 онд Зохистой Хөгжлийн Жендэр Төвийн санаачлагаар байгуулагдсан Толгойт хорооллын иргэдэд дэмжлэг үзүүлдэг орон нутгийн хөгжлийн төв юм.

Хаяг: Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг

Их наран, 3-р хорооны дэргэдэх гэр

Утас/Факс: 976-11-325627

Электрон шуудан: [wirc@magicnet.mn](mailto:wirc@magicnet.mn)

## АГУУЛГА

### Судалгааны тухай

*Судалгааны үндэслэл*  
*Судалгааны зорилго*  
*Судалгааны хүрээ*  
*Судалгааны арга зүй*  
*Судалгааны үе шат, зохион байгуулалт*  
*Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт*  
*Судалгааны явцаас авсан сургамж*

### I хэсэг: Боловсролын үйлчилгээнд хамрагдалтын өнөөгийн байдал Сонгосон бүлэгт хийсэн тоон судалгааны үр дүн

*Суурьшлын байдал*  
*Боловсролын байдал*  
*Нийгмийн халамжинд хамрагдсан байдал*

### II хэсэг: Боловсролын бодлогын дүн шинжилгээ ба сургууль завсардалтыг бууруулах арга замын санал

*Боловсролын эрх зүйн орчин*  
*Боловсролын бодлогын хэрэгжилт*  
*Сургууль завсардалт, түүний шалтгаан*  
*Сургуульд огт яваагүйн шалтгаан*

### Ашигласан материал

#### Хавсралтууд:

Хавсралт 1. Кейсүүд

Хавсралт 2. Өрхийн бүртгэлийн маягт

Хавсралт 3. “Боловсролын үйлчилгээнд хамрагдалтын байдал” чанарын судалгааны чиглүүлэх асуултууд

Хавсралт 4. “Боловсролын үйлчилгээнд хамрагдалтын байдал” кейс судалгаанд оролцогсдын нэрс, хаяг

## **СУДАЛГААНЫ ТУХАЙ**

### ***Судалгааны үндэслэл***

Боловсролын салбарт улсын төсвийн 20 хувь зарцуулагдаж, олон улсын хамтын ажиллагааны дэмжлэгийн багагүй хэсэг нь боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэгдсээр байгаа боловч бага, дунд боловсролын сургууль завсардалт ялангуяа шилжин ирэгсэд, ядуурал ихтэй, эмзэг бүлгийн өрхүүд олноор амьдардаг хотын захын гэр хорооллуудад нилээд хэмжээгээр байсаар байна.

Боловсролын салбарын мэдээ мэдээллээр сургууль завсардалтын шалтгааны талаар цуглуулан нэгтгэдэг мэдээллийг анхан шатанд сургуулиас, багш нараас авдаг тул үүнд сургуульд хамрагдаж байгаад завсардсан хүүхдүүдийн мэдээлэл л ирэх ба шалтгааныг тайлбарлахад багш нарын субъектив хандлага ч нөлөөлдгийг үгүйсгэх аргагүй юм. Ихэнх тохиолдолд хүүхдийг “сурах дургүй” гэж үнэлсэн байдаг ба хүүхэд юунаас болоод сурах дургүй байна. Хүүхдийн авьяас чадвар, эцэг эхийн нөлөө, амьдралын нөхцөл байдал, сургуулийн орчин дахь багш нарын болон хүүхдүүдийн зүгээс ирэх дарамт хэдий хэмжээгээр нөлөөлж байгааг энэхүү статистик мэдээлэл нь харуулж чадахгүй нь ойлгомжтой.

Сургуульд сурч байгаад завсардсан хүүхдүүдээс гадна шилжин ирсэн, бүртгэлгүй өрхийн хүүхдүүд боловсролын үйлчилгээнд бүрэн хамрагдаж байгаа эсэхийг хянах мэдээлэл хараахан алга. Шилжин ирсэн өрхүүдийг хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нар хариуцан бүртгэж түр оршин суух үнэмлэх олгон нийгмийн үйлчилгээнд хамруулах албан үүрэгтэй ч өнөөгийн байдлаар энэ нь хангалттай хэрэгждэггүй болох нь орон нутгийнхны дунд зохион явуулж буй хөгжлийн ажлын явцад харагддаг.

Ядуу өрхүүдийн хувьд хүүхдийг сургуулиас хөндийрүүлж буй нэгэн гол хүчин зүйл нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлт байгаа нь ажиглалтаар харагддаг боловч үүнд гэр бүл, эцэг эх болон сургууль, амьдарч буй орчин тус бүр ямар хэмжээгээр нөлөөлж байгааг, мөн хөвгүүд охидын хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй харилцан адилгүй жендэрийн хүчин зүйлс боловсрол эзэмшихэд нь мөн анхаарч судлаагүй байна. Энд мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамрагдалтын асуудал ч орно. Гэр хорооллын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ихэнх нь сургуульд явж, боловсролын бусад аливаа үйлчилгээнд хамрагдахгүй гэртээ байх нь түгээмэл ажиглагддаг.

Энэ бүгдээс харахад хүүхдүүдийн боловсролд хамрагдалтын бодит байдал, албан бүртгэл мэдээлэл, сургууль завсардалтын шалтгаан, хүчин зүйлсийг хүүхэд, гэр бүл, сургууль болон боловсролын тогтолцоо, орон нутгийн хүрээнд тодруулах хэрэгцээ тулгарч байгааг харуулж байна. Тоон судалгаа, статистик мэдээллийн хариу өгч чадахгүй байгаа эдгээр асуудлыг чанарын буюу кейс судалгааны аргаар илрүүлэн гаргахад энэхүү судалгаа хувь нэмэр оруулах болно. Мөн боловсролын салбарт чанарын судалгааг хөгжүүлэх, бодлого төлөвлөлтөд ашиглахад бодит дэмжлэг болно хэмээн найдаж байна.

### ***Судалгааны зорилго***

Сонгосон бүлэг дэх хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын бодит байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг кейс судалгааны аргаар илрүүлэн гаргах ба бодлогын дүн шинжилгээ хийхэд судалгааны зорилго оршисон.

### ***Судалгааны хүрээ***

Судалгаанд Улаанбаатар хотын Сонгино Хайрхан дүүргийн<sup>1</sup> 4-р хорооны 8-р хэсэг, 3-р хорооны 10-р хэсгийн өрхүүдийг хамруулсан. (Цаашид “Сонгосон хэсэг” гэнэ.) Энэ хэсэг нь шилжин ирэгсэд, бүртгэлгүй өрхүүд ихтэй тул кейс судалгааг эхлэн явуулахад тохиромжтой хүрээ хэмээн сонгосон.

### **Судалгааны арга зүй**

Судалгаанд тоон ба чанарын судалгааны арга зүйг ашигласан.

*Тоон судалгаа:* Тоон судалгааг сонгосон хэсгийн өрхийн бүртгэлд үндэслэн хийсэн. Засаг захиргааны анхан шатны нэгж болох хороо нь 2006 оноос эхлэн Үндэсний Статистикийн Хорооны тушаалаар өөрийн орон нутагт оршин сууж буй хүн ам, өрхийн тоо мэдээг үнэн зөв тодорхойлох, тэдний нийгмийн үзүүлэлтээр мэдээллийн сан бүрдүүлэхэд зориулж анхан шатны маягт болох “Хүн ам, өрхийн бүртгэл”-ийн дэврийг хөтөлдөг. Тиймээс энэхүү дэвтэр нь хүн ам, өрхийн талаарх засаг захиргааны анхан шатны мэдээлэл төдийгүй нийгэм, эдийн засаг болон хүн амын түүвэр судалгааны анхан шатны нэгж, хамрах хүрээг тодорхойлох суурь мэдээлэл болж чадах хууль эрх зүйн үндэстэй. Иймээс бид энэхүү өрхийн бүртгэлийг судалгаандаа ашигласан.

Хүн ам, өрхийн бүртгэл нь засаг захиргааны анхан шатны нэгжийн нийгэм, эдийн засаг болон хүн амын суурь мэдээлэл билээ. Энэ ч утгаараа тухайн орон нутгийн иргэдийн талаарх хамгийн бодит мэдээллийг агуулж байдаг.

Хамрагдсан өрхүүдийн болон тухайн өрхийн гишүүдийн боловсролын талаарх мэдээллийг хорооны “Хүн ам, өрхийн бүртгэл”-ийн дэврээс авч бүртгэн, түүнийгээ өрх тус бүрээр явж тулгалт хийж, баталгаажуулсан.

“Хүн ам, өрхийн бүртгэл”-ийн дэвтэрт суурилсан тоон судалгаагаар дараах мэдээллийг нэгтгэсэн. Үүнд:

1. Сууршлын байдал<sup>2</sup> **A6** ( 9 үзүүлэлтээр)
2. Боловсролын байдал<sup>3</sup> **A7** ( 9 үзүүлэлтээр)
3. 0-29 насны хүн амын СӨБ, сургуульд хамрагдалт<sup>4</sup> **A8** ( 11 үзүүлэлтээр)
4. Сургууль завсардсан<sup>5</sup> шалтгаан **A8.2** ( 5 үзүүлэлтээр)
5. Сургуульд огт яваагүйн шалтгаан **A8.3** ( 5 үзүүлэлтээр)
6. Сургалтын төлбөр хариуцах байдал<sup>6</sup> **A9** ( 4 үзүүлэлтээр)
7. Хөгжлийн бэрхшээлтэй эсэх **A15** ( 6 үзүүлэлтээр)
8. Нийгмийн халамжинд хамрагдсан байдал<sup>7</sup> **A16** ( 10 үзүүлэлтээр)

*Чанарын судалгаа:* Хагас бүтэцсэн асуултаар ярилцлага авсан. Чанарын судалгаанд ганцаарчилсан ярилцлагын аргыг хэрэглэсэн. Мөн сургууль завсардсан хүүхдүүдийн

<sup>1</sup> СХД нь нийслэлийн баруун жигүүрт оршдог хүн ам, нутаг дэвсгэрээрээ хамгийн том дүүрэг. 25 хороотой. 2009 оны 1-р сарын 1-ны байдлаар 52770 өрх, 232.3 мянган хүн амтай. Төрийн болон хувийн хэвшлийн 21 ерөнхий боловсролын сургууль, 41 цэцэрлэг, 24 өрхийн эмнэлэгтэй. Дүүргийн хэмжээнд 2008 оны байдлаар халамжийн үйлчилгээнд давхардсан тоогоор 180.0 мянган иргэнд 170 тэрбум төгрөгийн тусламж үзүүлсэн байна.

<sup>2</sup> Хорооноос бүртгэл хийж байх хугацаанд тухайн иргэн оршин сууж байгаа засаг захиргааны нэгжд 6 сараас дээш, доош хугацаанд амьдарч байгаа эсэхийг харгалзан сууршлын байдлыг тогтоодог.

<sup>3</sup> Энэ үзүүлэлтэнд 7 ба түүнээс дээш настай хүн хамрагдана. Боловсролтой эсэх болон боловсролтой бол ямар түвшний боловсролтойг тодруулах зорилготой.

<sup>4</sup> Боловсрол олгох ямар нэгэн шатны сургууль, цэцэрлэг, яслид хүмүүжин сурч байгаа хүн амыг хамруулна.

<sup>5</sup> Ерөнхий боловсролын сургуулийн аль нэг ангид сурч байгаад дахин суралцаагүй, сургуулиа орхисон хүүхдийг сургуульд завсардсан гэж үзэн бүртгэж байна.

<sup>6</sup> Бүх шатны сургуульд төлбөр төлсөн байдлыг тодруулах зорилготой.

<sup>7</sup> Тухайн иргэний нийгмийн халамжинд хамрагдсан байдлын талаарх мэдээллийг оруулдаг.

эцэг, эх асран хамгаалагчдаас нь “Танай хүүхэд яагаад сургуульд явахгүй байгаа шалгаан юу вэ?” гэсэн асуулттай нууц санал хураалтыг хайрцагаар мэдээлэл авсан.

### ***Судалгааны үе шат, зохион байгуулалт***

Судалгааг Зохистой Хөгжлийн Жендэр Төвийн судлаачид болон түүний Толгойт хороолол дахь “Нутгийн Хөгжлийн Төв”-ийн ажилтнуудаас бүрдсэн судалгааны баг хамтран гүйцэтгэсэн.

Судалгааны явцад сонгосон дүүргийн болон хорооны засаг захиргаа, холбогдох хүмүүстэй уулзаж, судалгааны талаарх мэдээлэл өгч хамтарч ажилласан нь судалгааг амжилттай хийгдэхэд ихээхэн түлхэц болсон.

Судалгааг 2009 оны 3-р сараас 7 сар хүртэл 4 сарын хугацаанд дараах 3 үе шаттайгаар хийсэн. Үүнд:

- 1- р үе шат: Сонгосон хэсгийн өрхүүдийн бүртгэлийг хорооны өрхийн бүртгэлээс авч, өрх тус бүрээр тэмдэглэл хөтлөн, өрхүүдээр явж тулгалт хийсэн.
- 2- р үе шат: Сургуулиас завсардсан болон сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн бодит тоонд тулгуурлан хүүхэд, эцэг, эх асран хамгаалагчидтай кейс судалгаа хийсэн.
- 3- р үе шат: Боловсролын хүртээмжийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлаар бодлогын зөвлөмж боловсруулсан.

Судалгааны тайлан 2009 оны 8 сард гарсан бөгөөд тухайн үед нь сургууль завсардсан хүүхдүүдийн талаар орон нутгийн байгууллагуудад мэдээлэл өгч байсан. Судалгааны дараагаар орон нутгийн засаг захиргаа, байгууллагуудаас ямар үйл ажиллагаа явуулсан, өөрчлөлт хэр гарсанг тандах зорилгоор 2011 оны 3 сард давтан судалгаа хийсэн.

Давтан судалгаагаар 2009 оны кейс судалгаанд оролцсон, сургуульд явдаггүй байсан 29 хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, хүүхдүүдтэй уулзан тэдний талаарх мэдээллийг шинэчилэн тодруулж, өнгөрсөн хугацаанд ямар өөрчлөлтүүд гарсан, ямар асуудал дээр өөрчлөлт гарч чадахгүй байгаа шалтгаануудыг гаргасан.

2009/2011 онд хийсэн кейс судалгааны үр дүнг харьцуулсан мэдээллийг боловсруулж, 2011 оны 3-р сарын 11-ны өдөр орон нутгийн иргэд, хороо, сургуулийн ажилтангуудад танилцуулах, цаашид анхаарах асуудлын талаар санал солилцох уулзалтыг Нутгийн Хөгжлийн Төвийн байранд хийсэн. Уулзалтаар орон нутгийн иргэд, засаг захиргаатайгаа хамтарч өргөжүүлэн бүх хорооныхоо түвшинд тус судалгааг явуулсан аргачлалаар явуулж, мэдээлэлтэй болгох, хэсгийн ахлагч нар сургууль засвардсан хүүхдүүдийн мэдээллээ сургуулийн нийгмийн ажилтанд өгч байх зэрэг асуудлыг дэвшүүлсэн тавьсан.



Зураг 1. Судалгааны үр дүнг хэлэлцэх уулзалт, 2011/3/11

## ***Судалгааны мэдээлэл цуглуулалт, боловсруулалт***

Судалгааны асуулга, хэрэглэгдэхүүнүүдийг судалгааны баг, ННХ-тэй хамтран боловсруулсан. БСШУЯ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй санал солилцсон.

Эхлээд сонгосон хэсгийн оршин суугчдын талаарх өрхийн мэдээллээс (Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр, Маягт ХАӨБ-2) өрхүүдийн болон тухайн өрхийн гишүүдийн боловсролын талаарх мэдээллийг бүртгэж, тусгай тэмдэглэл хийсэн ба энэ хэсэгт 4 судлаач ажилласан.

Бүх өрхүүдийн мэдээллийг нэгтгэн, өрх тус бүрээр нь бүртгэж авсны дараа өрх тус бүрээр тэмдэглэл хөтлөн, өрхүүдээр явж тулгалт хийсэн. Мэдээллийг судлаачдын болон орон нутгийн иргэдийн бүрэлдэхүүнтэй баг цуглуулсан. Багт нийт 12 хүн ажилласан.

Бүртгэлийн дараагаар сонгосон хэсгийн өрхүүдийн сургууль завсардсан болон сургуульд хамрагдаагүй хүүхдүүд, тэдний эцэг, эх гэр бүлийн кейст тулгуурлан чанарын судалгааг хийсэн. Кейс судалгааг сонгосон хэсгийн өрхүүдтэй нэг бүрчлэн уулзаж өрхийн болон сургуулийн бүртгэлтэй тулган сургууль завсардсан болон хамрагдаагүй хүүхдүүдийн бодит тоо, байршлыг гарган авсны дараа тэдгээр хүүхдүүдтэй болон эцэг, эх асран хамгаалагчтай нь ярилцаж авсан. Эцэг эх, асран хамгаалагчдаас өрхийн бүтэц, ажил эрхлэлт, орлого зэрэг нөхцөл байдлыг асууж тодруулсны дараа бэлдсэн чиглүүлэх асуулгын дагуу ярилцсан бөгөөд хүүхдүүдтэй ганцаарчлан уулзаж ярилцлага авсан.

Сургуулиас завсардсан болон сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн бодит тоонд тулгуурлан хүүхэд, эцэг, эх асран хамгаалагчидтай кейс судалгаа хийхэд нийт 4 судлаач ажилласан.

Судалгааны мэдээллийг өрхөөр, хүн тус бүрээр нь SPSS-18 программд оруулж, боловсруулалт хийсэн.

## ***Судалгааны явцаас авсан сургамж***

Судалгааны зорилгын дагуу боловсролын үйлчилгээний хүртээмжийн талаарх мэдээллийг сонгосон хэсгийн оршин суугчдаас авахдаа өрхөд бүртгэлтэй хүн бүрийг хамруулахыг хичээсэн ба мөн тухайн хэсэгт амьдарч байгаа бүртгэлгүй иргэдийг ч оролцуулсан. Судалгаа хийхэд өрхүүдээр явж, иргэдтэй уулзаж мэдээлэл авахад зарим хүндрэлүүд тохиолдсон ба цаашид анхаарал хандуулах хэд хэдэн зүйл ажиглагдсан. Энэ нь нэг талаас орон нутгийн Засаг захиргааны үйл ажиллагаатай, нөгөө талаас иргэдэд өөрсдөд нь буй асуудал, тэдний зан үйлтэй холбоотой байлаа. Үүнд:

- *Хүн ам, өрхийн бүртгэл:* Өрхөд гарсан өөрчлөлтийг бүртгэлд тусгахгүй удаж байна. Түүнчлэн өрх, хүн амын талаарх маягт дахь тэмдэглэгээний бүртгэл дутуу, бүртгэлийн кодчлолыг буруу хийсэн, мэдээллийн шинэчлэл жигд биш байна.
- *Хаягжилт:* Гудамж, хашаанууд эмх цэгцгүй, хаяг дугааргүйгээс айл өрхийг олж очиход хүндрэлтэй. Мөн нэг хаяг дээр 14 хүртэл өрх айлууд бүртгэгдсэн байгаа ба үүнийг цаашид анхаарахгүй бол бүртгэлийн системд хүндрэл учруулах нөхцөл бүрджээ. Жишээлбэл, 4-р хорооны 34-р гудамжны 101 тоот хаяг нь дээр 101-ийн “Ж” хүртэл 14 өрх айл хамрагдаж байна.
- *Бүртгэлгүй өрхүүд:* Хороонд ямар ч бүртгэлгүй түр оршин сууж байгаа гэсэн айл өрхүүд олон байна.

- *Өрхийн чадавх*: Иргэд өөрсдийн оршин сууж буй газрын хаягийг мэддэггүй, өрхийн гишүүд гэж хэнийг хэлэх, өрхөд нь хэдэн хүн харьяалагддаг, мөн тэдгээр хүмүүс нь ямар боловсролтой, нийгмийн халамжийн ямар үйлчилгээнд хамрагддаг талаар хангалттай мэдлэг мэдээлэл байхгүй байна. Өрхийн гишүүдийн бичиг баримт ч мөн гүйцэд бус байна.

Архидалт, ядуурал, хүчирхийлэл ихтэй орчинд өрхүүдээр судалгаа хийх явцад янз бүрийн хүмүүстэй харьцах хэрэгцээ гарах тул судлаачид хамтарч явах хэрэгтэй нь харагдсан. Мөн өвөл хөдөөнөөс айлууд олноор орж ирж өвөлждөг тул ийм чиглэлийн судалгааг өвлийн улиралд хийх нь илүү тохиромжтой юм. Түүнчлэн архидалт ихтэй гэр бүлийн хүүхдүүдэд учрах бүх талын эрсдэл өндөр, ирээдүй нь бүрхэг байгаа тул ийм гэр бүлийн хүүхдүүдийн нөхцөл байдлыг цаашид анхаарч гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй байна.

### Нэгдүгээр хэсэг:

## БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЛТЫН БАЙДАЛ

Сонгосон хэсгийн өрхүүдийн тоон болон кейс судалгааны үр дүнг энэ хэсэгт нэгтгэн харуулж байна. “Хүн ам, өрхийн бүртгэл”-ийн дэвтэрт суурилсан тоон судалгаагаар сонгосон хэсгийн **806 өрхийн 3110 хүний** сууршил, боловсрол, хөгжлийн бэрхшээл, нийгмийн халамжинд хамрагдсан байдлын талаарх мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн.

Кейс судалгаанд сонгосон бүлэг (СХД-ийн 3-р хорооны 10-р хэсэг Бага Нарангийн 51-57-р гудамж, 4-р хорооны 8-р хэсэг Мал тууврын зам 9-р гудамж, Их Нарангийн 26-29-р гудамж) дотроос сургуулиас завсардсан болон сургуульд огт яваагүй **29 хүүхэд**, тэдний гэр бүл хамрагдсан.

Судалгаагаар сонгосон 2 хорооноос тус бүр нэг хэсгийг авч хүн амын (Хороодын засаг захиргаанаас өгсөн эхний мэдээгээр нийт 600 гаруй өрхтэй) бүртгэлийг шүүн үзэж, өрх тус бүрийг судалгааны багаас боловсруулсан маягтын дагуу бүртгэж, тэмдэглэж авсан (Өрхийн бүртгэлийн маягтыг Хавсралт 1-ээс харна уу.) ба нийт **718 өрхийн** мэдээллийг маягтанд буулган авсан. Үүний дараа маягтын дагуу өрхүүдэд тулгалт хийхэд 88 өрх нэмж бүртгэгдсэн. Энэхүү 88 өрх нь хорооны албан ёсны мэдээлэлд бүртгэлгүй байсан өрхүүд юм. Ингээд нийт 806 өрхийн гишүүдийн боловсролын байдалд тодруулалт хийгдсэн.

### Суурьшлын байдал

Өрхийн бүртгэлийн дэвтэрт бүртгэгдсэнээр тус орон нутагт (хороо, хэсэгт) бүртгэлтэй **2778** хүн байсан боловч тулгалтын дараа 88 өрхийн 332 хүн (үүнээс нь хүүхэд) огт бүртгэгдээгүй байсан бөгөөд тэдгээр өрхүүдэд 0-29 насны нийт 33 хүн сургууль завсардсан байлаа.

### Хүснэгт 1. Сонгосон хэсгүүдэд оршин суугчдын бүртгэлийн байдал

Бүртгэлийн байдал	3-р хорооны 10-р хэсгийн оршин суугчдын тоо	4-р хорооны 8-р хэсгийн оршин суугчдын тоо	Нийт оршин суугчдын тоо
Бүртгэлтэй	1194	1584	2778
Бүртгэлгүй	276	56	332
Бүгд	1470	1640	3110

Хүн амын сууршлын байдлыг авч үзэхэд нийт 3110 хүний 93.1 хувь нь тухайн орон нутгийн байнгын оршин суугчид (Зураг 1.) гэжээ. Түүнчлэн удаан хугацаагаар байнга



оршин суусан гэж өөрсдийгөө үзсэн хүмүүс энд мөн хамрагдсан. Хүн амын суурьшлын байдал нь өрхийн бүртгэлийн дэвтэрт 9 үзүүлэлтээр тусгагдаж байгаа бөгөөд бидний судалгаанд хамрагдагсдын тухайд дараах дүр зураг харагдаж байна.

Зураг 1. Хүн амын суурьшлын байдал, хувиар



### Боловсролын байдал


Судалгаанд хамрагдсан нийт хүн амын боловсролын байдлыг өрхийн бүртгэлийн дэвтэрт 9 үзүүлэлтээр, 0-29 насны хүн амын СӨБ, сургуульд хамрагдалтыг 11 үзүүлэлтээр, сургууль завсардсан шалтгаан болон сургуульд огт яваагүйн шалтгааныг тус бүр 5 үзүүлэлтээр, сургалтын төлбөр хариуцах байдлыг 4 үзүүлэлтээр гаргасныг доор харуулав.

Боловсролын түвшин	Хувь
- Дээд	8.8
- Тусгай мэргэжлийн дунд	4.5
- Мэргэжлийн анхан шатны	2.4
- Бүрэн дунд	46.2
- Суурь боловсрол	26.8
- Бага боловсрол	8.7
- Боловсролгүй	2.3

Боловсролгүй гэж хариулагсдын дотор 6.6 хувь нь бичиг үсэггүй хүмүүс байна.

0-29 насны хүн амын СӨБ, сургуульд хамрагдалт, хувиар

	Дотоодод	Гадаадад
- Ерөнхий боловсролын сургууль	50.8	0.3
- Мэргэжлийн сургалт үйлвэрлэлийн төв	2.1	0.0
- Их, дээд сургууль	8.4	0.1
- Ясли	0.1	
- Ердийн цэцэрлэг	7.8	
- Халамжийн цэцэрлэг	0.2	
- Сургууль завсардсан	<u>2.7</u>	
- Гэртээ	27.5	



2009 онд судалгааны мэдээллээр “0-29 насны 33 хүн сургуульд огт явж байгаагүй гэсэн бөгөөд түүнээс 1991 оноос хойш төрсөн 29 хүүхэд” байсан. 2011 оны 3 сард хийсэн давтан судалгаагаар эдгээр 29 хүүхдийн талаарх мэдээлэл хороодын өрхийн анхан шатны бүртгэлд орсон эсэхийг шүүн үзсэн. Ингэхдээ болон **иргэний шинэчилсэн бүртгэл**<sup>8</sup> болон өмнө хийгдэж байсан өрхийн бүртгэлд тулгуурлан хүүхдүүдийн мэдээллийг авсан.

Бүртгэлээс авсан гэрийн хаягийн дагуу хүүхдүүдийн гэрээр явж энэ өнгөрсөн хоёр жилийн хугацаанд тухайн хүүхдүүд болон тэдний гэр бүлд ямар өөрчлөлт бий болсон талаар ярилцлагын судалгаа хийсэн. Хорооны бүртгэлээс харахад 24 хүүхэд нь хороондоо бүртгүүлсэн, 5 хүүхэд хорооны бүртгэлд байхгүй байлаа. Зарим хүүхдийн хаяг нь өөрчлөгдсөн байсан бөгөөд шинэчилсэн хаягийн дагуу хүүхдүүдийн гэрээр явж үзэхэд 29 хүүхдийн 8 (28%) хүүхэд хаягандаа, 11(38%) хүүхэд өмнө байсан хаягаа өөрчилсөн<sup>9</sup>, 3(10%) хүүхэд нь бүртгэлгүй гэхдээ бичиг баримттай хөдөө орон нутгаас шилжин ирсэн., 7(24%) хүүхдийн амьдарч байгаа газар нь олдоогүй, эдгээр хүүхдүүдийн 4 хүүхэд нь хороонд бүртгэлгүй, 3 хүүхэд нь бүртгэлтэй байсан.

Эдгээр 22 хүүхдийн сургуульд хамрагдалтын байдлыг харуулбал,

- 6 хүүхэд сургуульд огт яваагүй байна.
- 13 хүүхэд сургуулиас завсардсан байдалтай, одоогоор хичээлдээ явахгүй байна.
- 3 хүүхэд сургуульд явж байгаагийн 1 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд, 2 хүүхэд албан бус боловсролын төвд байна.

Судалгааны багынхан хүүхдүүдтэй уулзахаар явж байх үедээ хороондоо бүртгэлтэй, бичиг баримттай хэдий ч бага ангиасаа сурууль завсардсан 3 хүүхдийг нэмж илрүүлсэн.

### ***Нийгмийн халамжинд хамрагдсан байдал***

Нийгмийн халамжинд хамрагдсан байдлыг өрхийн бүртгэлээс 10 үзүүлэлтээр гаргасан.<sup>10</sup> Нийт судалгаанд хамрагдсан 37.8 хувь нь нийгмийн халамжинд хамрагдсан байна. Үүний 90.2 хувь нь хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж авагчид, 8.2 хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр авагчид байна. Судалгаанд хамруулсан нэгжүүдийн 70 хувь нь ядуу өрхүүд байдаг гэсэн хорооны албан статистик байдаг

<sup>8</sup> 2010 онд хийсэн.

<sup>9</sup> Эдгээр хүүхдүүд хэдийгээр хороондоо бүртгэлтэй боловч тус 2 хорооныхоо газар нутагт өөр хаяг дээр амьдарч байгаа гэсэн үг.

<sup>10</sup> Өнөөдөр Монгол улсын иргэн, өрх гэр бүлүүд “**Нийгмийн халамжийн тухай**” Монгол улсын хуулийн (2005 он) дагуу нийгмийн халамжинд хамрагдаж байна. Энэхүү хуулийн зорилт нь нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг дэмжих, амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болгоход чиглэгддэг. Хуульд зааснаар “Нийгмийн халамж” гэж нийгмийн эмзэг бүлгийн иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээг үзүүлэх замаар тэдний амьжиргааг дэмжихэд чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг хэлнэ гэжээ.

Нийгмийн халамж, түүний төрөл: **Нийгмийн халамжийн тэтгэвэр:** Ахмад настны, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний, Дөрөв ба түүнээс дээш хүүхдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх/50 насаанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр, **Нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ:** Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох, ахмад настан болон ХБИ-г асарч буй иргэнд олгох тэтгэмж, хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, **Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ:** Нийгмийн эмзэг бүлгийн иргэнд амьдралын итгэл үнэмшл олгох, ажлын дадлага, авъяасыг дэмжих, зөвлөх, сургах, хэрэгцээ сонирхолоороо нэгдсэн нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг зохион байгуулалатанд оруулж, тэдгэрэйг хөдөлмөр эрхлүүлэх, орлоготой болгох, ядуурлаас гаргах, тэднийг төсөл хөтөлбөрт зуучлах, түр байрлуулан асрамжлах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх

хэдий ч ихэнх гэр бүлүүд нийгмийн халамжинд хамрагдаж чадахгүй байгаа нь судалгааны үед ажиглагдсан.

## Хүснэгт 2. Нийгмийн халамжинд хамрагдсан байдал

Үндэсний статистик мэдээгээр Монгол улсын хэмжээнд 2005 онд 754.8 мянган хүн ам халамжийн үйлчилгээнд хамрагдаж байсан бол 2006 онд энэ тоо 1324.2 болон нэмэгдсэн. Энэ нь хүн амын 51 хувь нь халамжийн үйлчилгээнд хамрагдаж байна гэсэн үг.

	Халамжийн төрөл	3-р хороо 10-р хэсэг	4-р хороо 7-р хэсэг	Бүгд
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	55	42	97
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1	5	6
3	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	0	0	0
4	Нийгмийн эмзэг бүлгийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт тусламж	0	0	0
5	Хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж	513	548	1061
6	Төрөлжсөн асрамжийн газрын үйлчилгээ	2	1	3
7	Ганц бие ахмад настны оршуулгын зардал	0	1	1
8	Гэр бүлд үзүүлэх тусламж	4	0	4
9	Шинэ хүүхдэд үзүүлэх мөнгөн тусламж	1	0	1
10	Алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж	1	2	3
	<b>Бүгд</b>	<b>577</b>	<b>599</b>	<b>1176</b>

2009 онд хийгдсэн эхний судалгааны байдлаар нийт 332 өрх хороондоо ямарч бүртгэлгүй байсан ба тэдгээр өрхийн 1991 оноос хойш төрсөн 29 хүүхэд сургуульд хамрагдаагүй байсан.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд тэдгээр 29 хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдсан байдлын талаар давтан судалгааг хийхэд 22 хүүхэд хамрагдсан. Эдгээр 22 хүүхдийн гэр бүлээс “Таны амьдралд 2009 оноос хойш ямар нэгэн өөрчлөлт гарсан уу?” гэж асуухад бүгд ямар нэгэн өөрчлөлт гарсан гэж харулсан байна.

Давсан судалгаанд хамрагдсан 22 хүүхдийн өнөөгийн өрхийн орлогын эх үүсвэрийг судалж үзэхэд,

- 41 хувь нь буюу 9 өрх “Нарангийн энгэр”-ийн хогийн цэг дээр хог түүн амжиргаагаа залгуулдаг,
- 27 хувь нь 6 өрх орлогын эх үүсвэрээ хэлээгүй
- 23 хувь нь буюу 5 өрх гэртээ ажилгүй,
- 9 хувь нь буюу 2 өрх бусад газар ажилладаг /тогооч, ачигч/ байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдлыг асуухад 91 хувь нь хамрагдсан, 9 хувь нь одоогийн байдлаар эрүүл мэндийн даатгалгүй гэжээ.

Нийгмийн халамжийн ямар нэгэн үйлчилгээнд хамрагдсан байдлыг авч үзэхэд 55 хувь нь хамрагдсан, 27 хувь нь хамрагдаагүй, 18 хувь нь хамрагдсан эсэхээ мэдэхгүй байна. Өрхийн гишүүн бүр хүний хөгжлийн сан<sup>11</sup> гаас олгогдож буй мөнгөө бүгд авч байна.

<sup>11</sup> Хүний хөгжлийн санг Засгийн газраас байгуулсан.

**Хоёрдугаар хэсэг:**  
**БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ БА**  
**СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТЫГ БУУРУУЛАХ АРГА ЗАМЫН САНАЛ**

*Эрх зүйн орчин*

Хүн амын боловсрол нь тухайн улс орны хөгжлийн чухал хүчин зүйл билээ. Дэлхийн улс орнууд хүн амынхаа боловсролын асуудалд, ялангуяа бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх явдлыг чухалчлан үзэж байна. Тухайлбал, Мянганы хөгжлийн зорилтуудын нэгд 2015 он гэхэд хүн бүрийг суурь боловсрол эзэмшүүлэх, тийм нөхцөл бололцоог хангах талаар дэлхийн улс орнуудад уриалж байна.

Боловсролыг хүртээмжтэй байлгахад төрийн хүлээж буй үүргийг боловсролын салбарт хүн бүр сурч боловсрох тэгш боломжоор хангагдсан эсэхээр хэмжиж болох юм.

Монгол Улсын иргэний сурч боловсрох эрх, үүргийг тодорхойлон баталгаажуулсан эрх зүйн үндсэн баримт бичиг бол 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хууль юм. Үндсэн хуулинд Монгол Улсын иргэн бүр ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмших талаар хуульчилсан<sup>12</sup>.

УИХ-аас 1995 онд “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг батлан хэрэгжүүлж байна.<sup>13</sup> Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод бүх нийтийн ерөнхий боловсролыг иргэдэд төлбөргүй олгох, суурь боловсролыг заавал эзэмшүүлэхээр тусгасан. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсролын тухай хуульд<sup>14</sup> “хүүхэддээ 16 хүртэл насанд нь суурь боловсрол заавал эзэмшүүлэх, суралцах хүсэл, сонирхлыг нь хааж боогдуулахгүй байх” нь эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг байхаар заасан нь охид хөвгүүдийг сурах, боловсрол эзэмших эрхээ бүрэн хэрэгжүүлэх баталгаа болж өгсөн.

Боловсролын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх зорилгоор Боловсролын тухай багц хуульд нэмэлт оруулж, 2007 онд УИХ-аар батлуулснаар ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Иргэдийн сурч боловсрох үйл явц, түүний баталгаа, боловсролын салбарын үйл ажиллагааг зохицуулсан суурь эрх зүйн баримт бичгүүдийг идэвхитэй мөрдөх, хэрэгжилтийг хангах, үр дүнгийн хяналтыг тодорхойлоход “Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”<sup>15</sup> чухал ач холбогдолтой байна.

***Боловсролын бодлогын хэрэгжилт***

Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулиуд 2002 оны 5

<sup>12</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэгт Монгол улсын иргэн “сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно” гэж заасан байдаг.

<sup>13</sup> Энэхүү бодлогын баримт бичигт “Монгол Улсын оршин тогтнох, хөгжин дэвших эх сурвалж бол монгол хүний тасралтгүй хөгжиж байх, оюун ухааны чадавхи, боловсрол мөн” хэмээн тунхаглаад “Боловсрол нь Монгол улсын иргэн бүрийг бүх талаар хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн дэвшил, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, материаллаг болон оюуны баялгийг бүтээх чухал эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа мөн” гэж тодорхойлон боловсролыг төрөөс нийгмийн ТЭРГҮҮЛЭХ САЛБАР болгон хөгжүүлэхээр заасан. (УИХ-ын 1995 оны 6-р сарын 8-ны өдрийн 36 дугаар тогтоол)

<sup>14</sup> 46.2 дахь хэсэгт

<sup>15</sup> Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс “Үр дүнд түргэн хүргэх санаачлага” түншлэлээс Монголын боловсролын салбарыг хөгжүүлэхэд 2007-2009 онд 27.2 сая ам.долларын буцалтгүй тусламжийг олгох гэж байгаагаас 2007 онд 8.4 сая ам.долларын тусламжийг бага боловсролд зориулан олгожээ.

дугаар сарын 3-ны өдөр шинэчлэгдэн батлагдаж боловсролын шинэтгэлийн хүрээнд жил бүр нэмэлт өөрчлөлт оруулж байна.

Дээр дурдсан эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг бүрэн зохион байгуулах, үр дүнд хүргэх, ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор олон тооны журам, дүрэм, заавар зэргийг УИХ, Засгийн газар, эрх бүхий байгууллагуудаас батлан мөрдөж байгаа хэдий ч улсын хэмжээнд ЕБС-ийн хүртээмж бага хэвээр байна. Тухайлбал анги дүүргэлт 45-50 болж ЕБС-ийн сургалт дунджаар 2.7 ээлжтэй, зарим сургууль 3 ээлжтэй байна<sup>16</sup>. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зориулсан 5 сургууль улсын хэмжээнд ажиллаж нийт ХБ-тэй хүүхдүүдийн 6.0 орчим хувь нь л эдгээр сургуульд суралцаж байна.

Сургуулийн болон Өрхийн мэдээлэл зөрүүтэй байна. Сургууль завсардсан, шилжсэн хүүхдүүдийн мэдээллийг орон нутгийн нийгмийн ажилтан дор бүр нь мэдэгдэхгүй, шалтгааныг тодруулах хяналт тавьж дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь хуулийн заалт, өөрчлөлтүүд бодит байдалд хэрэгжихгүй байгааг харуулж байна. Үүний нэг жишээ нь СХД-ийн ЕБС-аас завсардсан хүүхдийн тооноос харагдана. СХД-ийн ЕБС-аас завсардсан хүүхдийн судалгааг хороодын болон сургуулийн нийгмийн ажилтан нараас авч нэгтгэдэг гэх боловч тэдгээрийн өгсөн тоонууд нь хоорондоо зөрүүтэй байдгийг албаны хүмүүс үгүйсгэхгүй байгаа юм. СХД-ийн 25 хорооноос 2009 онд 156 хүүхэд сургуульд завсардсан гэх мэдээ байна. Гэтэл 2 хорооны 2 хэсгээс л сургуульд завсардсан 33 хүүхэд байгааг энэхүү судалгаа харууллаа.

Сургуулийн орчин багш нарын хандлага (магадгүй сургуулийн менежментийн арга барил, тогтолцоо) хүүхдүүдийг сургууль завсардуулахад нэг хүчин зүйл болж байгааг хүлээн зөвшөөрч боловсролын бодлого, багш нарын сургалтын агуулгад энэ асуудлыг тусгайлан оруулах талаар бодлогын хувьд дэмжихгүй байна.

Хуулийн дагуу төр нь хүүхдийн сурч боловсрох нөхцөлийг хангах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хүүхэд сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүргээ биелүүлэхгүй байна.

### ***Сургууль завсардалт, түүний шалтгаан***

Хүүхдүүдийн сургууль завсардаж байгаа хэд хэдэн шалтгаан байна. Үүнд:

1. Хүн амын бүртгэл, статистик мэдээллийн зөрүү, түүний чанар
2. Гэр бүлийн амьдралын гачаал
3. Бичиг баримтгүй байдал
4. Харьяалалын бус байдал
5. Сургууль хол
6. Сургуулийн хамт олон гадуурхсан
7. Удаан ойлгоцтой, тархины саажилттай, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас зэрэг орж байна.

2011 оны 3 сард хийсэн давтан судалгаагаар сургуульд явахгүй байгаа шалтгааныг тодруулахад,

- Сурах дургүй (11),
- Ар гэрийн амьдрал хүнд учраас (8), үүнээс 7 нь ажил хийж өрхийн орлого нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах, 1 нь хэн нэгийг асардаг гэжээ.
- Хэрхэн сургуульд оруулахаа мэдэхгүй (5)
- Сургууль болон багш нарын харьцаанаас болоод (4) гэсний шалтгаанд ядуу байгаагийн дарамт, хэл ярианы бэрхшээл, багш нарт ад үзэгддэгээс гэжээ.
- Сургуулийн хүүхдүүдээс, муу хувьцас, эцэг эхийн амьдралаас, албан буст явдаг хүүхдүүдийг бусад хүүхдүүд шоолдог, насны ялгаанаас болоод ичдэг (4)

<sup>16</sup> Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын илтгэл, 2003

- Хөгжлийн бэрхшээлтэйгээс (1)

Сургуульд ороход нь хэнээс ямар туслалцаа үзүүлж байсанг асуусан. Үүнд төрийн бус байгууллага, боловсролын байгууллага, хорооны захиргаа, танил найз нөхөдөөс нь тусласан байна.



*Хүн амын бүртгэл, статистик мэдээллийн зөрүү, түүний чанаргүй байдал*

Судалгааны эхний шатанд хороодын сонгосон хэсгийн өрхүүдийн бүртгэлийн дэвтрийг шүүж үзэхэд 3-р хорооны 10-р хэсэгт 3 хүүхэд, 4-р хорооны 7-р хэсэгт 4 хүүхэд сургууль завсардсан гэж бүртгэгдсэн байсан боловч өрхүүдэд тулгалт хийсний дараа судалгаа хийгдсэн **2 хэсэгт амьдарч буй хүүхдүүдийн 2.7 хувь нь** (33 хүнээс 29 нь хүүхэд, түүнээс 6 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй) **сургууль завсардсан байгаа нь илэрсэн.**

Дээрх сургууль завсардсан 0-29 насныхны 21 нь эрэгтэй, 12 нь эмэгтэй байгаа ба 1991 оноос хойш сургууль завсардсан буюу 18-аас доош насны 16 эрэгтэй, 9 эмэгтэй нийт 29 хүүхэд байна.

Энэ байдлаас үзэхэд дүүрэг, хотын хэмжээнд сургууль завсардалтын статистик мэдээлэлд ороогүй маш олон хүүхэд байх магадлалтай нь харагдаж байна. Хэрэв сургууль завсардалт хорооны хэмжээнд жигд тархалттай байна гэж үзээд дээрх тоог статистик аргаар тархааж үзвэл зөвхөн 3-р хороонд 500 гаруй хүүхэд сургууль завсардсан байх магадлалтай байна. Хэдий бидний сонгосон хэсгүүд нь шилжилт хөдөлгөөн, ядуурал ихтэйгээс бусад хэсгүүдээс илүү олон хүүхэд сургууль завсардаж байгааг үгүйсгэх аргагүй боловч СХД-ийн 25 хорооноос 2009 онд нийт 156 хүүхэд сургуульд завсардсан гэх статистик мэдээ бодит байдлаас хол зөрүүтэй болох нь харагдаж байна.

3-р хорооны нутаг дэвсгэрт байх 65-р сургуульд сонгогдсон 2 хэсгээс сургуульд байгаа мэдээллээр нийт 294 (3-р хорооны 10-р хэсгээс 199, 4-р хорооны 7-р хэсгээс 95) хүүхэд сурдаг байна. Дээрх хэсгүүдээс тус сургуульд сурч байгаад завсардсан хүүхдийн тоо сургуулийн нийгмийн ажилтны өгсөн мэдээгээр 12 байна. Тус 2 хэсгийн хүүхдүүд явдаг сургуулиуд огт суралцаж байгаагүй завсардсан, сургуульд огт ороогүй хүүхдүүдийн тоог мэдээндээ хамруулах боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Сургуулийн болон Өрхийн мэдээлэл ийнхүү зөрүүтэй байгаа нь нэг талаас сургууль завсардсан, шилжсэн хүүхдүүдийн мэдээллийг сургуулийн нийгмийн ажилтан орон нутгийн нийгмийн ажилтанд дор бүр нь мэдэгдэхгүй байгаагаас, нөгөө талаас орон нутгийн нийгмийн ажилтан уг хүүхдийн сургууль завсардсан бодит шилтгааныг тодруулах, хяналт тавьж гэр бүл, хүүхдэд хэрэгцээтэй дэмжлэгийг үзүүлэх арга замыг хайхгүй байгаагаас болж байна. Үүний нэг жишээ нь СХД-ийн ЕБС-аас завсардсан хүүхдийн тооноос харагдана. СХД-ийн ЕБС-аас завсардсан хүүхдийн судалгааг хороодын болон сургуулийн нийгмийн ажилтан нараас авч нэгтгэдэг гэх боловч

тэдгээрийн өгсөн тоонууд нь хоорондоо зөрүүтэй байдгийг албаны хүмүүс үгүйсгэхгүй байгаа юм.

### Хүснэгт 1. СХД-ийн ЕБС-аас завсардсан хүүхдийн тоо, шалтгаан

№	Завсардсан шалтгаан	Нийт
1	Өвчний гачигдалаас болж завсардсан	27
2	Ядуурал, ар гэрийн байдлаас	73
3	Бичиг баримтгүйгээс /хөдөөнөөс/	20
4	Багшийн харьцаанаас	3
5	Хаягтаа байхгүй, байршил тодорхойгүй	13
6	Ажил хийдэг	9
7	Шалтгаангүй	7
8	Бусад	4
	<b>Нийт</b>	<b>156</b>

Эх үүсвэр: СХД-ийн Боловсролын хэлтэсийн мэдээлэл, 2009 оны 3-р сарын 31-ний байдлаар

Өнөөгийн өрхийн бүртгэлд ашиглаж байгаа үзүүлэлтүүд нь хүүхэд, түүний гэр бүл дэх сургууль завсардалтын бодит шалтгааныг харуулж чадахгүй, сургууль завсардалтыг бууруулахад бодит дэмжлэг болохгүй, хэт явцуу, категорчилсон байдалтай байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Статистик мэдээлэл зөрүүтэй, бодит байдлыг гаргаж өгч чадахгүй байгаа нь боловсролын бодлогын хэрэгжилт, түүнийг сайжруулах арга зам, хөрөнгө нөөцийн хуваарилалтыг буруу тодорхойлох үндэс болж байна гэж үзэж болохоор байна.

2009 онд хийгдсэн судалгаанд сургууль завсардсан хүүхдүүд **ар гэрийн гачаал** болон **бусад** гэсэн шалтгааныг нэрлэсэн бөгөөд давтан судалгаагаар ямар өөрчлөлт гарсан талаар харьцуулахад дараах үр дүн харагдаж байна. Үүнд 1991 оноос хойш төрсөн, сургууль завсардсан нийт 29 хүүхдийн хувьд 24 хүүхэд болон тэдний гэр бүлийнхэн харъяалал бүртгэлтэй болсон, бүгд бичиг баримттай болсон нааштай өөрчлөлтүүд байгаа хэдий ч хүүхдүүдийн сургуульд хамрагдалтанд ахицтай өөрчлөлт ороогүй байна. 22 хүүхдийн 3 нь сургуулиуд явж байна. Тэдний сургууль завсардаж буй гол шалгаан нь :

1. Сурах дургүй байдал
2. Ар гэрийн амьдралын байдал
3. Хэрхэн сургуульд орохоо мэдэхгүй байгаа
4. Сургууль болон багш нарын харьцаа
5. Ичдэг
6. Хөгжлийн бэрхшээлтэй

#### Гэр бүлийн амьдралын гачаалт байдал

Өрхийн дэвтэрт сургууль завсардсан хүүхдүүдийн шалтгааныг **ар гэрийн гачаал** болон **бусад** гэсэн хоёр л хувилбараар бүртгэсэн байдаг. “Ар гэрийн гачаал” хэмээх шалтгаан нь олон янзын утга агуулгатай байгаа нь тэдгээр хүүхдүүдтэй, мөн эцэг эхтэй нь уулзаж ярилцахад харагдсан. Үүнд голчлон, эцэг эхийн аль нэг нь хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд охид дүүгээ харах, өвчтэй хүнээ асрах шалтгаанаар сургуулиас завсардаж байна. (Кейс 1), өрх толгойлсон, өвчтэй, 3-аас дээш хүүхэдтэй эмэгтэйчүүд амьдрал нь ядуу боломжгүйгээс хүүхдүүдээ сургуульд явуулж чадахгүй завсардуулж байна.

Ар гэрийн гачаал, амьдралыг боломжгүй байдлаас сургуулиас завсардсан охид, хөвгүүдтэй хийсэн ярилцлагаас харахад эцэг эх, асран хамгаалагч нь зөвшөөрснөөс сургууль завсардсан хүүхдүүд гэрийнхээ амьжиргаанд нэмэр болохын тулд хүүхдийн хөдөлмөрт татагдан орсон байна. Энэ нь ийм хүүхдүүдийг эргүүлэн боловсролын үйлчилгээнд хамруулахад тэдний хөдөлмөр эрхлэлт, өөрөөр хэлбэл өрх гэр нь тэдний олох орлогоос хараат болсон байдал гол бэрхшээл болж байна.

Хагас өнчний улмаас сургуульд завсардсан хүүхдүүд ч амьдралын гацаалаас болсон гэж үзэж байгаа нь манай улсын боловсролын болон нийгмийн бодлогын уялдаа муу байгааг харуулж байна.

Хүүхдүүд сургуульд сурахыг хүсдэг, сургуульд явж байгаа хүүхдүүдийг харахад сайхан санагддаг тухайгаа илэрхийлэн хэлсэн бөгөөд эцэг эхийнхээ “амьдралын боломжгүй”, “хөөцөлдөх завгүй” гэх зэрэг тайлбарыг “гэрийнхэн сургуульд явуулах дургүй” хэмээн ойлгосон байлаа. Ажил хийдэг учраас гэх тайлбар нь ч мөн сургууль завсардалтын шалтгаантай нэгэн адил бусад шалтгаантай хосолмол шинжтэй байна.

Сургууль завсардсан хүүхдүүдийн эцэг эхтэй хийсэн ярилцлагын явцад эдийн засгийн ядуурлаас илүүтэй чадавхийн ядуурал хүүхдээ сургууль завсардуулах шалтгаан болж байгаа нь харагдлаа. Тухайлбал өөрсдийнхөө болон хүүхдийнхээ тухайд тодорхой төлөвлөгөөгүй, өнөөдрөөр л амьдарч байгаа болон хүүхдийнхээ хүсэл сонирхлыг мэдэхгүй, сонирхохгүй байна (Кейс 5). Ийм байдал нь хүүхдээ сургуульд явуулахаас хөдөлмөр эрхлүүлэн сайндаа л “Дэлхийн зөн” зэрэг байгууллагаас явуулдаг албан бус сургалтад хамруулах, мөн тэдний түгээдэг хоол, хувцас зэргийг авахыг илүүд үзэх арчаагүй байдалд хүргэж байна. Нөгөө талаас ийм байдалд сургууль, орон нутгийн эцэг эхчүүдэд нөлөөлөх, хүүхдүүдийг сургууль завсардуулахгүй байхад чиглэсэн уялдаатай үйл ажиллагаа алга байна.

#### *Бичиг баримтгүй байдал*

Сүүлийн жилүүдэд гэр бүлийн бүтэц өөрчлөгдөн, шилжих хөдөлгөөн ихэсч нэг талаас хүүхдүүд хууль ёсны эцэг эх, асран халамжлагчдаасаа холдон, хамт амьдрагсад нь хүүхдэд анхаарал халамж тавих бодит болон эрх зүйн чадамж дорой байгаа нь хүүхдүүдийг сургууль завсардуулах шалтгаан болж байна.

Бичиг баримтгүй нь улмаас сургууль завсардаж буй гол шалтгаан нь аймаг хотын хоорондох шилжүүлгийн баримт бичгийн зөрчилөөс үүдэлтэй байна. (Кейс 2) Түүнчлэн эмээ өвөө, хамаатан садныдаа амьдардаг хүүхдүүд бичиг баримт, шилжүүлэггүй гэсэн шалтгаанаар сургуульд огт яваагүй тохиолдол гарсан ба ярилцлагын үеэр гарсан. (Кейс 9)

#### *Харъяаллын бус байдал*

Анги дүүргэлт хэтэрсэн шалтгаанаар харъяаллын бус хүүхдүүдийг сургууль нь авдаггүй байна. Энэ нь хот суурин газар, тэр дундаа хотын захын хороололд ерөнхий боловсролын сургуулийн ачаалал хэт өндөр байгаатай холбоотой. Энэ нь хүүхдүүдийг сургуульд завсардуулахад нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байгааг харуулж байна. (Кейс ..)

#### *Сургууль хол байдал*

Сургууль хол, тээврийн хэрэгсэл явахгүй учраас хүүхдүүдээ сургуульд явуулж чадахгүй байна. Төвөөс хэт алслагдан амьдарч буй өрхүүд хүүхдүүдээ сургуульд



явуулж чадахгүй байгаа нь хот төлөвлөлтийн буруу бодлогын нөлөөнөөс үүдэлтэй. (Кейс 5)

### *Сургуулийн хамт олон гадуурхсан*

Багш нарын харьцаа хандлага, сургуулийн орчин дахь хүчирхийлэл хүүхдүүдийг сургууль завсардуулж буй цогц хүчин зүйлүүдэд нэрмээс болж байгаа ба гол үүрэг гүйцэтгэх (Кейс 6) тохиолдол ч гарч байна.

Хичээлдээ муу гээд ангийн багшийн шахалт, гадны нөлөөнөөс хичээлдээ дургүй болж сургуулиас гаргасан тохиолдол байна. Түүнчлэн сургууль багшаас шаардаж буй хувцас, эд зүйлсийг тэр бүр өгч чадахгүй байгаагаас

Бидний судалгаанд хамрагдсан сургууль завсардсан хүүхдүүдийн олонх нь өсвөр насны хүүхдүүд бөгөөд ирээдүйдээ итгэлгүй, гутранги, үе тэнгийнхнээсээ ичдэг (“...Өнгөрсөн амьдралаа бодохыг ч хүсдэггүй...”) байдалтай бөгөөд сургууль завсардсанаас хойш ямар нэгэн сургалтанд хамрагдаж байгаа эсэх талаар асуухад хүүхдүүдийн 20.0 хувь нь дүүрэг, хороо, олон улсын тусламжийн байгууллагуудын зохион байгуулдаг сургалтанд хамрагджээ. Эдгээр сургалтууд нь гол төлөв мэргэжлийн баримжаа олгох сургалт байдаг талаар судалгаанд оролцсон хүүхдүүд хэлсэн байна. Хүүхдүүдийн нөхцөл байдал, хэрэгцээнд тохирсон боловсролын хоцрогдол нөхөх, нийгэмшүүлэх үйлчилгээг бий болгох хэрэгцээ харагдаж байна

### *Удаан ойлгоцтой, тархины саажилттай, хөгжлийн бэрхшээлтэй байдал*

“Удаан ойлгоцтой, оюуны хомсдолтой” гэдэг нь эцэг эхчүүдийн өөрсдөө, мөн сурч байх үед нь ангийн багшийнх нь өгсөн тодорхойлолт байх нь цөөнгүй тохиолдож байсан ба мэргэжлийн эмчийн дүгнэлт оношлогоо байхгүй байлаа. Хүүхэд үнэхээр сурах сонирхолгүйн улмаас сургууль завсардсан тохиолдол бидний судалгаанд гараагүй нь энэ тайлбарын цаана гэр бүлийнхнийх нь боловсролыг үл ойшоох, хүүхдэд хайхрамжгүй хандах, сургууль, багш нар, ангийн хамт олны хандлага, харьцааны улмаас үүссэн сэтгэл зүйн төлөв байдал бөгөөд тэр бүхнийг хүүхэд үгээр илэрхийлэн тайлбарлаж чадахгүйгээс “Би сургуульд дургүй” гэсэн дүгнэлтэд хүрдэг ба эцэг эх нь ч “хүүхэд маань өөрөө дургүйгээс сургуулиасаа гарсан” гэж тайлбарлах нь ажиглагдсан (Кейс 7).

ХБИ-ийн бүрэн оролцоог нийгмийн бүхий л түвшинд нэмэгдүүлэх, тэдний саад тотгоргүй амьдрах, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлэхийг бодлогын хувьд шийдвэрлэсэн билээ<sup>17</sup>. Түүнчлэн ХБ-тэй хүүхдийг жирийн хүүхдүүдтэй хамт ЕБС-иар бага, суурь боловсрол эзэмшүүлэх, мөн тусгай ангид багшлах боловсон хүчинг бэлтгэх, техник хэрэгслэлээр хангах, уян хатан сургалтын хөтөлбөр боловсруулах талаар тусгаж энэхүү ажлыг цэцэрлэг, ясли, сургуульд хамрагдаж буй ХБ-тэй хүүхдийн тоо, эзлэх хувиар үр дүнг тооцож байхаар хүртэл заасан байдаг. Гэтэл бодит байдалд энэхүү хууль, бодлогууд хэрэгжихгүй, сургууль завсардах, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь хөгжлийн бэрхшээл болоод байгаа билээ.

Нийт сонгосон хэсгээс судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 24.5 хувь нь (13) хүүхэд байна.<sup>18</sup> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дийлэнх нь хөдлөх

<sup>17</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих Үндэсний хөтөлбөр (2006-2012)

<sup>18</sup> Хөгжлийн бэрхшээлтэй байдлыг 6 үзүүлэлтээр гаргасан.<sup>18</sup> Сонгосон хэсгийн өрхийн бүртгэлийн мэдээлэлд нийт 3110 хүний 53 нь (1.7 хувь) хөгжлийн бэрхшээлтэй гэжээ. Тэдний 30.2 хувь нь хөдлөх эрхтний, 24.5 хувь нь хэл, яриа, сонсголын, 24.5 хувь нь оюун ухааны, 9.4 хувь нь харааны, үлдсэн хувь

эрхтний болон оюун ухааны бэрхшээлтэй 14-17 насны хүүхдүүд байна. Тэдний 6 нь сургууль засвардсан ба 4 нь үүнийгээ хөгжлийн бэрхшээлтэйгээс, 2 нь амьдралын гачаалаас болсон гэж тайлбарлаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд сургуульд явах нь нилээн хүндрэлтэй байгаа нь кейс судалгааны үр дүнгээс харагдсан. Боловсролын хүртээмжийн хүрээнд тусгай хэрэгцээтэй хүүхдийн сурч боловсрох эрхээ тэгш эдлэх боломжийн тухай асуудлыг чухалчлан авч үздэг. Гэтэл өнөөдөр бодит байдалд сургууль, түүний гадаад орчны дэд бүтэц болон сургалтын хэрэглэгдэхүүн нь ХБХ-дэд сурч боловсрох тэгш эрхээ эдлэх тэгш боломжийг хязгаарлаж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Ялгаварлан гадуурхалтыг хуулиар хориглосон хэдий ч бодит байдалд хэрэгжихгүй байгаа нь харагдаж байна.

---

нь байнгын асаргаатай хэвтрийн хүмүүс байна. ХБИ-ийн нийгмийн халамжинд хамрагдалтын байдлыг харахад 37.7 хувь нь нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг гэжээ.

## **Хавсралт 1. Кейсүүд**

### **Кейс 1**

Хүүхдээ 5-р ангиас нь гаргасан. Өмнө нь 9-р сургуульд дараа нь 65-р сургуульд сурч байсан. Аав нь хөлөө хугалсан учраас 2 дүүг нь харуулах гэж сургуулиас нь гаргасан. Одоо охин маань гэртээ дүү болон аавыгаа хардаг. Гаргахаас өөр аргагүй байсан болохоор гэр бүлээрээ зөвлөлдөөд шийдсэн. Манай хүүхэд тооны хичээлд их сайн, монгол хэлний хичээлд дургүй байсан. Сайн сурдаг байсан ч сүүлдээ дунд сурдаг болсон. Үүнд сургууль сольсон нь нөлөөлсөн байх. Сургуульд сурахын нэг хэцүү нь мөнгө их нэхдэг. Сайхан нь найзуудтай, мэдлэг боловсролтой байх. 65-р сургуульд сурдаг байхад нь ангийн охидууд нь их дарамталдаг, зоддог байсан. Ангидаа гурав дөрвөн л найзтай байсан. Багш болон найзууд нь буцаад сургуульдаа ороорой гэж хэлдэг байсан. Миний бодлоор сургууль завсардаж буй хүүхдүүдийн ихэнх нь ар гэрийн боломж муу, сургуулийн багш нараас, өөрсдөө сурах сонирхолгүйгээс болдог байх. Бас ар гэрийнхэн нөлөөлдөг. Бид буцааж сургуульд оруулахыг боддог. Хүүхдээ 8-р ангийн гэрчилгээтэй болох, уншиж бичиж сурах нь чухал гэдгийг ойлгож байгаа ч чадахгүй л байна. Охин маань хааяа хогийн цэг дээр ажиллаж байгаа. Ажиллаад өдөрт 2000-3000 төг олдог. Хогийн цэг дээр хамт ажилладаг нэг найзтай, тэр нь бас сургуульд сурдаггүй. Охин маань надтай юмаа сайн ярьдаггүй. Гэхдээ зураг гоё зурдаг, загвар их сонирхдог санагддаг, уг нь загвар өмсөгч болговол гадаад их яваад, зүгээр юм гэж боддог. Охиноо хүмүүжилтэй, боловсролтой, хүнийг хайрлаж чаддаг хүн болоосой гэж бодож байна. Орон сууцанд амьдруулах юмсан гэж бас боддог. *(37 настай, эмэгтэй)*

Би 65-р сургуулиас 5-р ангиасаа гарсан. Дүүгээ харах хүнгүй болсон болохоор гарсан. Ээж тэгж шийдсэн. Би сургуульд байхдаа зургийн хичээлд хамгийн дуртай байсан. Дунд сурдаг байсан. Өглөө эрт босож хичээлдээ явах хамгийн хэцүү ч, найзуудтай байх нь гоё. Ангийн зарим охидууд их танхай, намайг зоддог байсан. Найзууддаа сургуулиас гарсны дараа үнэн учраа хэлсэн. Намайг гарах үед 3-4 хүүхэд сургуулиас гарсан. Ар гэр нь боломжгүйгээс гарсан байх. Багш нар хэл ам таталдаг гээд надад дургуй байсан. Одоо өдөрт дүүгээ хараад хогийн цэг рүү гардаг. Аав, ээж өвчтэй үед мөнгө олох гэж найзтайгаа хамт хогийн цэг рүү гардаг. Өдөрт 2000 төг олдог. Олсон мөнгөө хоол хүнсэндээ зарцуулдаг. Хэрэв сургуульд орвол 65-р сургуульд буцаж орохгүй, 62-р сургуульд орно. Одоо хуучин ангидаа орж чадахгүй болсон. Бид нар сургуулийн талаар ярьдаггүй өнгөрсөн амьдралаа санахыг ч хүсдэггүй. *(13 настай охин)*

### **Кейс 2**

2004 онд Сэлэнгэ аймгаас шилжиж ирсэн. Ирснээсээ хойш ажилгүй байж байгаад одоо хогийн цэг дээр ажилладаг болсон. Амьдралын боломжгүйгээс сургуульд одоо хүртэл хүүхдүүдээ оруулж чадаагүй. Энд ирээд 8-р сард 65-р сургуульд оруулах гэж хөөцөлдөж үзсэн шилжүүлэг байхгүй гээд аваагүй. Хүүхдүүдэд өмсөх хувцасыг нь ч авч өгч чадахгүй юм. Ийм байдалтай сургуульд явуулбал хүүхдүүдэд шоглуулж сургуульд явах сонирхолгүй болно гэж айдаг. Хүүхдүүд маань хүүхдийн мөнгөө авахаар хичээлийн хэрэглэлээ аваад сургуульд явна гэж ярьдаг. Хүүгээ багад нь цэцэрлэгт явуулж байсан. Манай хүүхдэд найзууд байдаггүй. Үсэгнүүдээ бүгдийг таньдаг, тоолж, нэмэж, хасаж чаддаг. Одоо хүү маань хааяа хогийн цэг дээр ажилладаг. Манай өдрийн орлого 5000 төг болдог. Олсон мөнгөө ихэвчлэн хоол хүнсэндээ зарцуулдаг. Манай хүүхэд том болоод цэргийн захирагч болно гэж ярьдаг. Өөрөө сургуульд ормоор байна гэдэг. Бид шилжүүлгээ хийлгээд оруулья гэж хэлдэг. Хүүгээ ямар ч байсан боловсролтой хүн болгоно гэж бодож байна. *(Аав нь 43 настай)*

1-р ангидаа ороод л гарсан. Сургуульд сурна гэж гэрийнхэндээ хэлж байгаагүй би өөрөө сурах дургүй. Уншиж, бичиж чадахгүй. Хэрвээ сургуульд сур гэвэл би сурна. Гэрийнхэн сургуульд сур гэж хэлдэггүй. Гэхдээ Увс аймагт амьдардаг эмээ намайг сургуульд сур гэж дандаа ярьдаг. Би сургуульд орвол хичээлийн хувцас, хэрэгсэл, бас их мөнгө төлөх хэрэгтэй байх. Ямар сургуульд орохоо мэдэхгүй байна. Гэрийнхэн нэг удаа сургуульд оруулах гэж хөөцөлдөж байсан тэрнээс хойш хөөцөлдөж байгаагүй. Хааяа хог дээр гарахаар өдөрт 1000 төг олоод ээждээ өгдөг. Сургуульд сурдаг, сурдаггүй найзууд байдаг. Сургуульд сурдаггүй найзуудтайгаа хоорондоо сургуулийн талаар ярилцдаггүй. Том болоод цэргийн хүн болох бас лам болмоор байна. Яагаад гэвэл манай ах лам. *(14 настай хүү)*

### **Кейс 3**

Энэ манай ахын охин. Ээж нь нэг сартайд нь хаяад явсанаас хойш би өсгөсөн. Төрсний гэрчилгээ нь байхгүйгээс болоод сургуульд оруулж чаддаггүй. Бид гэрчилгээг нь олох гэж их хөөцөлдсөн. “Эх нялхас”-т төрсөн болохоор нь тэнд шүүлгэсэн боловч гарч ирээгүй. Өөрөө сургуульд оруулж өгөөч гэж гуйдаг боловч эгч нь завгүй байна гэж хэлдэг юм. Би гэрээрээ үсэг тоо зааж өгдөг. Одоо А-3 хүртэл үсэг мэддэг болсон. Хоёр зуугийн дотор тоог нэмж, хасдаг болсон. Одоо нэг настай дүүгээ хараад гэртээ байдаг, гэрээ цэвэрлэдэг. Бичиг баримт нь л хэрэгтэй, тэгвэл би сургуульд оруулж чадна. Сургуульд сурдаг найзууд байгаа. Сургуульд оруулбал 65-р сургуульд оруулах нь л зүгээр байх. Гэртэй ойрхон. Өөрөө аав ээжтэйгээ цуг байж сургуульд ормоор байна гэж ярьдаг. Дүүгээ би эмч болоосой гэж боддог яагаад гэвэл би өөрөө эмч болно гэж боддог байсан ч чадаагүй. *(Эгч нь 20 настай)*

Ээж миний бичиг баримтыг аваад явсан гэсэн. Тэгээд би сургуульд орж чаддаггүй. Би ганц ч удаа хүүхдийн мөнгө авч байгаагүй. Ахтайгаа цуг хороогоор яваад бичиг баримтаа хөөцөлдсөн ч гарч ирээгүй. Сургуульд ормоор байна гэж би зөндөө хэлдэг, гэрийнхэн юу ч хэлдэггүй. Эгч надад үсэг, тоо зааж өгдөг. Би арвын дотор нэмж, хасах бас А үсэг л мэднэ. Есүсийн сүмд хааяа очдог, хоол өгдөг юм. Манай найзуудыг Агиймаа, Мөнхцэцэг гэдэг. Тэд сургуульд явдаг. Сургуульд явах гоё гэдэг. Нэг найз маань цэцэрлэгт явдаг. Сургуульд орвол дэвтэр ном хувцас хэрэгтэй. Том болоод зайрмагны үйлдвэрт ажилламаар байна. Одоо би гэрээ цэвэрлэдэг, дүүгээ хардаг. Дорнотод амьдрахыг хүсдэг. Яагаад гэвэл тэнд манай эгч амьдардаг. Би 2 удаа очиж байсан.

*8 настай охин*

### **Кейс-4**

Би огт сургуульд явж байгаагүй. Сургуульд сурах дуртай, уншиж, бичиж сурвал гоё. Гэхдээ уншиж чаддаггүй. Сургуульд ормоор байсан ч гэрийнхэн амьдралын боломжгүйгээс явуулж чадахгүй байна гэж боддог. Сургуульд ормоор байна гэхээр ээж, аав хоёр хэрэггүй гэдэг. 62-р сургуульд сурмаар санагддаг. Сургуульд сурдаг нэг найз байдаг. Тийм ч сайн найзууд биш. Нэг удаа 65-р сургуульд орох гэж очиж байсан. Хүүхдүүд бүртгээд дууссан гэж хэлсэн. Сургуульд ороход мөнгө хэрэгтэй гэж бодож байна. Хогийн цэг дээр хог түүгээд өдөрт 2000-3000 төг олдог. Тэр олсон мөнгөө ээждээ өгдөг. Гэрээсээ би ганцаараа хогийн цэг рүү явдаг. Сургуульд явдаггүй зургаан найзтай. Олсон мөнгөө ихэвчлэн хоол хүнсэндээ зориулдаг. Том болоод эмч болж, хувийн эмнэлэгтэй болохыг хүсдэг. 9 давхар байрны 8-р давхарт нь 2 өрөө байранд амьдрахыг хүсдэг. *(15 настай хүү)*

Манай хүүхэд 1-р ангиасаа гарсан. 9-р сургуульд сурч байхад нь 65-р сургуульд харъяалалтай гээд гаргасан. Тэр сургууль нь манай гэрээс хол байдаг. Хүүхэд 65-р сургуульд явах дургүй байгаа. Буцаад хуучин ангидаа ормоор байна гэж ярьдаг.

Хичээлдээ дунд зэрэг сурдаг байсан. Гэрт нь хичээлийг нь давтуулдаг хүн байдаггүй болохоор энэ байдал дунд нөлөөлдөг байх. Сургуульд явуулахад хувцас хичээлийн хэрэглэл гэх мэт зүйл их хэрэгтэй байдаг. Олон найзтай болохоор ухаан нь тэлдэг гэж би боддог. Амьдралын бололцоо муутай болохоор хүүхэд маань өөр сургуульд шилжих дургүй байгаа шиг санагддаг. Сургуульд нь эргэж оруулах талаар хөөцөлдөж үзнэ. Заавал харъяаллын сургуульд оруулна гэвэл хэцүү л болох байх даа. Хүү одоо гэртээ байдаг. Хажуу айлын үеийнхээ хүүхдүүдтэй найзалдаг. Би хүүхдээ мэргэжилтэй л болгох нь чухал гэж боддог.

*Ээж нь хийсэн ярилцлагаас*

### **Кейс-5**

Би 65-р сургуулийн 2-р ангид сурдаг байсан. Манай ээж сургууль хол болохоор чөлөө ав гээд гарсан. Манай анги өглөө ордог. Өглөө явах их хэцүү харанхуй, гудамжны дундуур явахдаа нохойноос их айдаг. Манай сургууль урагшаа их хол байдаг. Хичээлдээ дуртай хааяа онц, муу аль алиныг нь авдаг. Тооны хичээлд дуртай. Эрдэм ном сураад ном дэвтэрээ цүнхэндээ хийгээд явах нь гоё. Ангийн дөрвөн найз байдаг. Багшдаа хааяа муухай үг (*зайл гэж*) хэллээ гэж сандал өргөөд шийтгүүлдэг. Одоо дүүгээ хараад гэртээ байдаг. Буцаад сургуульдаа орно. Том болоод эмч болмоор байна. Яагаад гэвэл өвчтэй хүмүүсийг эдгээдэг гоё. Би сургуультай ойрхон гэртэй баймаар байна. (*8 настай охин*)

Охин 65-р сургуульд сурч байсан. Би өөрөө зах дээр зайрмаг зардаг. Тэгээд хүүхдээ хичээл тасалж байгааг нь мэдэхгүй юм. Охиноо сургуулиас нь гаргахгүй. Манай хүүхэд дунд сурдаг. Сургууль хол байх нь хүндрэлтэй байдаг. Сайхан нь хүүхэд маань эрдэм номтой болно. Ангийнх нь найзууд байдаг. Энэ хавьд сургууль, цэцэрлэгээс их хол учраас хүүхдүүд сургуульд явж чаддаггүй. Ээж аав нь ажилтай учраас байнга хүргэж өгч чадахгүй болдог. Одоо хичээл нь орохоор буцаагаад ангид нь оруулна. Хааяа очиж багштай нь уулздаг. Охин маань одоо гэртээ байдаг. Том болоод ажил хөдөлмөр эрхлэх чадвартай, боловсролтой хүн болоосой гэж боддог.

*Ээж нь, 45 настай*

### **Кейс-6**

Гульсара манай хамгийн бага охин. 65-р сургуулийн 7-р ангийнхаа дундаас гарсан. Гол шалтгаан нь монгол хэлээр муу ярьдаг хүүхэд байсан. Хүүхэд маань хичээлдээ муу байсан. Ангийн багшид нь их гомдож байна. Сургуулийн захиргаанаас их шахдаг байснаас хичээлдээ сууж чадахгүй болсон. Нөхөр бид хоёр сургуулийн захиргаатай уулзаж сургах гэж их хөөцөлдсөн боловч бүтээгүй. Миний бие муу байсан учраас нөхөр заргалдана гэхэд нь хэл ам гаргаад хэрэггүй гэж бодоод би болиулсан. Ангийнх нь хүүхдүүд их шоолж, гадуурхдаг байсан. Ангидаа нэг ч найзгүй байсан. Сургуульд сургаж боловсролтой хүн болгоё л гэж бодож байсан. Хүүхдүүдийг сургах ёстой биз дээ. Ангидаа ганцаараа казах байсан юм. Би сургуулийн захиралд их гомдож явдаг. Одоо охин гэртээ гэрийн ажилд тусалдаг. Цаашид сургах сонирхолтой байсан боловч сургуульд оруулж чадаагүй. Одоо 65-р сургуульд оруулахгүй гэж боддог. Тэрнээс хойш манай охин ичээд үеийнхээ хүүхдүүдтэй тоглож, найзлахаа больсон. Дандаа өөрөөсөө жижиг хүүхдүүдтэй нийлдэг юм. Охиноо мэдлэг боловсролтой хүн болоосой гэж боддог. (*Ээж нь, 43 настай*)

65-р сургуулийн 7-р ангийг 2006 онд төгсөөгүй гарсан. Ангийн багш Буриадхүү гэдэг биеийн тамирын багш хүн байсан. Намайг монгол хэлэндээ муу гээд хөөсөн. Ангийн багш, захирал, хичээлийн эрхлэгч ангид орж ирээд дандаа гар гэж хэлдэг байсан. Надтай хамт 2 хүүхдийг хөөсөн. Яагаад гэсэн намайг хичээлдээ муу, үймүүлдэг гэдэг байсан. Манай ээж сургуулийн захиргаатай их уулзаж ярьсан ч нөлөөлөөгүй. Тэгээд

ээжийн бие муудаад дахин хэл ам хийгээгүй. Хамгийн хэцүү нь би ганцаараа казах байсан. Ангийн хөвгүүд их гадуурхаж, шоолдог байсан. Би ангидаа нэг ч найзгүй байсан. Надтай хүүхдүүд нийлдэггүй байсан. Би их хичээлдээ дуртай. Ангийн хүүхдүүд сургуулиас гарч байгааг мэдэж байсан боловч юу ч хэлээгүй. Одоо найзууд байгаа, гэхдээ надаас дүү хүүхдүүд байгаа. Сургуульд орох сонирхолтой. Багш нар нь хүүхдийн төлөө сайн ажилладаг байвал орно. 65-р сургуульд ормоор л байна гэрт ойрхон учраас. Одоо би ээжийн гэрийн ажилд тусалдаг. Тогооч болохыг мөрөөддөг. *(17 настай охин)*

### **Кейс-7**

Би бага байхдаа орноос унаад тархи хөдлөөд, тэгээд эмнэлэгт нугасны ус авсанаас хөл муутай болсон гэдэг. 1-р ангиасаа сургуулиас гарсан. Дараа нь Улаанзагалмайн албан бус сургалтанд явдаг байсан. Ээж хүргэж өгч, авдаг байсан боловч ажилтай болохоор хүргэж өгч чадахгүй болсон. Миний тэрэг их том болохоор авч явахад хэцүү, хүүхдийн таягтай болвол сургуульд өөрөө явж чадна. Гэрийнхэндээ байнга сургуульд ормоор байна гэж хэлдэг. Би сургуульд явах дуртай бичиж чадна, уншиж чадахгүй байгаа. Сургуульд ороход ном дэвтэр хэрэгтэй. Одоо би гэртээ юм бичиж байгаа. Сургуульд явдаггүй найзууд байгаа тэдний ээж аав нь ажилдаа яваад гэрээ сахиад үлддэг. Тэр хүүхдүүдтэй би сургуульд орьё гэж ярьдаг. Би том болоод барилгын ажил хийнэ гэж боддог. Хөдөө амьдармаар байна, яагаад гэвэл агаар нь сайхан. *(11 настай хүү)*

Манай хүү сургуульд явж байгаагүй. 4-р хороонд явагддаг байсан Улаанзагалмайн албан бус сургалтанд явуулдаг байсан. Одоо төсөл дууссан учраас явагдахаа больсон гэсэн. Хөлийн шөрмөс нь гэмтсэн болохоор хөл нь муухан мэдээтэй байдаг. Ганцаараа явж чаддаггүй учраас би байнга тэвэрч сургуульд нь хүргэж өгөх болдог. Би өрх толгойлсон эмэгтэй учраас ажил хийж амьдралаа авч явах хэрэгтэй. Ийм учраас хүүгээ сургуульд оруулж чаддаггүй. Өөрт нь тохирсон таягтай бол ойрхон сургуульдаа яваад байж чадна. Хүү маань сургуульд явах их сонирхолтой, хичээлдээ маш дуртай байсан. Хамгийн хэцүү нь хүргэж өгч, авах нь байсан. Найзууд ихтэй, ангийн хүүхдүүд нь сайн ханддаг юм. Одоо бүгд л гэртээ байгаа сураг сонссон. Сургуульд явдаг байхад цэвэрхэн, өөртөө анхаараад сайхан байсан. Одоо гэртээ л байдаг. Том болоод ажил хийгээд ээждээ мөнгө олж өгнө гэж ярьдаг. Барилгачин болмоор байна гэдэг юм. Миний хувьд хөл дээрээ л явдаг болчихвол болно доо. *(Ээж нь, 37 настай)*

### **Кейс 8**

Миний нөхөр 2008 онд машинд дайруулж, хөлөө хугалаад одоо хэвтэрт гэртээ байдаг. Том охин маань аавыгаа болон дүү нараа асрах хэрэгтэй болоод сургуулиас гарсан. 5-р ангидаа 9-р сургуульд сурч байхад багш нь харъяаллын сургуульдаа сур гээд бичиг хэргийг нь өгөөд явуулсан байсан. Бидний амьдралын түвшин муу байдалд ч үүнд бас нөлөөлсөн. Сургуулиас маш их юм нэхдэг байсан. Манайх орлогогүй болохоор өгч чаддаггүй байсан болохоор багш нар их загнадаг байсан. Наад захын хувцас хунар барьдаг цүнх дэвтэр номноос өгсүүлээд авах юмны үнийг нь дийлэхгүй насных нь хүүхдийн юм авч чадахгүй, мөнгөндөө тааруулж авдаг. Тийм юмнаас болж ангийхнаасаа их ичингүйрч явдаг байх гэж би боддог. Бас гадаад үзэмж, өнгө мөнгө их хардаг болчихсон байна.

### **Кейс 9**

8 настай хүү 68 настай эмээгийнхээ хамт айлын байшинд өрөө түрээслэн амьдардаг. Тэд 2 жилийн өмнө Баянхонгор аймгаас нүүж ирсэн боловч эмээ нь Баянхонгорт банкинд тэтгэврээ барьцаалан зээл авсан тул өрөө төлөхөөс нааш шилжүүлгийг нь өгөхгүй. Иймд тэд хороонд бүртгүүлж чадаагүй байна. Хүүгийн төрсний гэрчилгээ,

эрүүл мэндийн даатгал зэрэг бичиг баримтыг Баянхонгорт албан бусаар алт олзворлодог ээж нь авчирч өгөхгүй байгаа нь хүүхдийн мөнгийг Баянхонгорт авч байх сонирхолтойгоос болж байна. “Хүү маань хүүхдүүд сургуульд яваад гоё юм аа л гэдэг. Би өөрөө үсэг бага сага заадаг. Бас тоо заасан. Зуугийн дотор нэмж хасч чадна. Харин бичихдээ тоогоо буруу харуулаад биччихдэг. Уг нь юм сурах сэргэлэн хүү байгаа юм”

*Эмээгийн яриа*

### **Кейс 10**

17 настай хүү 4-р ангиасаа сургууль завсардсан. “Анх Баянбүрдийн дэргэд 4-р сургуульд явж байсан. Гэр хорооллын хүүхдүүд байранд амьдардаг хүүхдүүдийг үзэхгүй, зодож дээрэлхдэг байсан. Манайх байранд байсан. (Хорооны нийгмийн ажилтан энэ айлг хөдөөнөөс нүүж ирсэн ба нэн ядуу айл байсан гэж хэлснээс үзэхэд хүү түүнээсээ их эмзэглэдэг тул худал хэлсэн нь тодорхой болсон). Тэгээд хэд хоног таслахаар хичээлээ ойлгохоо болиод дургүй хүрээд явахаа больсон. Уг нь багш орой нь давтлага өгч, орой нь нөхөртэйгөө гэрт хүргэж өгдөг байсан. Багш маань миний төлөө их явсаан. Би айлын бага, эрх байсан болохоор ээж аав оролдоод ч дийлээгүй. Тухайн үедээ сургуульд явахгүй байхад гоё санагдаж байсан. Хүмүүсийг харахад суралгүй гоё амьдарч болмоор санагдаж байсан. Одоо бол харамсдаг. Дараа нь манайх энд нүүж ирээд би 65-р сургуульд орсон. Тэгэхдээ 4-р ангиа төгсөөгүй байснаа алгасаад чадах байх гээд шууд 5-р ангид орсон. Тэгээд хичээгээд ч сайн ойлгохгүй байсан. 65-р сургуулийн багш нар надаас залхаад хувийн хэрэг зөрчилтэй гээд гаргачихсан. Сүүлд 62-р сургуульд нэг орох гээд шалгалт өгөх шахсан боловч ийм том болсон хүүхдийг бага ангид оруулахгүй гэсэн. Би сая гар утасны сургалтад явсан. Багш нь бидний үеийн мөртлөө их зантай пээдгэр болохоор нь дургүй хүрээд гарсан. Сургууль, хороон дээр сургалт хийвэл би лав очихгүй. Хүүхдүүд хараад шоолно, ярина, аягүй бол найз охинд маань хэлнэ шүү дээ. (11-р ангид сурдаг найз охинтой. Түүндээ сургууль завсардсанаа нуугаад хэлдэггүй). Харин хэн ч мэдэхгүй газар өөр хэргээр юм шиг дуудаад бие биеэ сайн мэддэг найз хэдэн хүүхдэд хичээд зааж хоцрогдол нөхвөл очно. Надтай адилхан хүүхдүүд зөндөө бий. Аав ээж маань коллежид оруулна л гэдэг. Гэтэл би бараг сайн бичиж чадахгүй болохоороо ичээд байна. Уг нь ядахдаа бичгийн чадвараа сайжруулаад өөрийгөө хөгжүүлмээр л байна. Тэгвэл ороод сурчихаж чадах байх гэж бодож байна. Одоо аавынхаа микронд жолооч хөлслөд баё блок цохиод сард дор хаяж 300000 төгрөг олдог. Олсон мөнгөөрөө идэж уух юм аваад үлдсэнээр нь бильярд тоглоод дуусдаг. Боловсролын гэрчилгээ олж аваад коллежид орж гагнуурчин, барилгачин болохыг хүсдэг. Би 25 хүрч байж, орох орон, мөнгө олох машинтай, ажилтай болж байж гэрлэнэ гэж боддог. “Хүүхдүүд РС тоглоомоос болж сургуулиас их гарч байсан. Голцуу эрэгтэй хүүхдүүд ингэж сургуулиас гардаг. Харин охид бол хөвгүүдээс болж их гардаг. Хөвгүүд тэр охинтой унтсан гэж худал цуу тарааснаас охид хэл аманд ороод ичээд хичээлдээ ирэхээ больчихдог. Хөвгүүд зүгээр л эр хүн болох гэж тэгдэг байхгүй юу. Охид бас царай муутай, хувцас муутай гээд дооглохоор л гарчихдаг ч явдал бий. Уг нь дэмий л дээ. Завсардсан охид голцуу л буруу замаар орчих гээд байдаг.” “Эрүүл мэндийн хичээлийг охид хөвгүүдэд тусад нь заавал зүгээр юм шиг санагддаг. Жишээ нь бэлгэвч хэрэглэх тухай хамтад нь заахад харьцаа нь задгай болоод хамаагүй ярьж, өдөж эхэлдэг.”

### **Кейс-21**

Би огт сургуульд явж байгаагүй. Амьдралын боломжгүйгээс л гэдэг. Би уншиж чаддаггүй. Сургуульд сурах гоё байх аа, уншиж бичиж сурна. Сургуульд ормоор байна гэхээр ээж, аав хоёр хэрэггүй гэдэг. Нэг удаа 65-р сургуульд орох гэж очиж байсан. Тэгсэн хүүхдүүдээ бүртгээд дууссан байсан. Сургуульд ороход мөнгө хэрэгтэй шүү дээ. Одоо би хогийн цэг дээр хог түүгээд өдөрт 2000-3000 төг ээждээ өгдөг. Гэрээсээ би л ганцаараа хогийн цэг рүү явдаг. Сургуульд явдаггүй зургаан найзтай. Би том болоод

эмч болно. Хувийн эмнэлэгтэй болохыг хүсдэг. Бас 9 давхар байрны 8-р давхарт нь 2 өрөө байранд амьдрахыг хүсдэг.

15 настай, хүү

## Хавсралт 2. Өрхийн бүртгэлийн маягт

### Хавсралт 3. “Боловсролын үйлчилгээнд хамрагдалтын байдал” чанарын судалгааны чиглүүлэх асуултууд

#### 1. Эцэг эх, асран хамгаалагчтай ярилцлага хийхэд чиглүүлэх асуултууд

Хүү\охин тань сургуульд сурч байсан уу?

Тийм	Үгүй
Хүү\охин тань хэддүгээр анги төгссөн бэ?	Хүү\охин тань яагаад сургуульд ороогүй вэ?
Хаана, аль сургуульд сурч байсан бэ?	Сургуульд орё гэж хэлж байсан уу? Та нар, та юу гэдэг вэ?
Яагаад сургуулиас гарсан бэ?	
Хэн сургуулиас гаргахаар шийдсэн бэ? Гэрийн бусад хүн яаж хандсан бэ? Хүүхэд өөрөө гарсан бол хэн, юу нөлөөлсөн бэ? Сургуульд нь үлдээхийн тулд та юу хийсэн бэ?	Хүүхэд тань сургуульд сурах дуртай юу? Яагаад? Уншиж, бичиж чадах уу? Ном уншдаг уу? Хэн зааж өгсөн бэ? Чадахгүй бол яагаад зааж өгөөгүй вэ? сурья гэдэг үү?
Хүүхэд сургуульд ямар дүн авдаг байсан бэ? Ямар хичээлд дуртай, ямар хичээлд дургүй байсан бэ?	Хүү\охинд тань сургуульд сурдаг найзууд бий юу? Сургуульд сурдаг хүүхдүүдтэй яагаад нийлдэггүй вэ?
Хүүхэд сургуульд явуулахад юу хамгийн хэцүү байдаг вэ?	
Сургуульд сурахад юу нь хамгийн сайхан байсан бэ?	
Ангийнх нь хүүхдүүд ямар байсан бэ?	
Ангидаа найзуудтай байсан уу? сургуулиас гарах гэж байгааг найзууд нь мэдсэн үү? Юу гэсэн бол?	
Хүүхдүүд ер нь яагаад сургуулиас гараад байна вэ?	
Сургуулиас гараад хүүхэд юу хийсэн бэ?	
Хүүхдээ сургуульд буцааж оруулах уу? Хэзээ орох вэ? Яагаад? Сургуульд оруулахад юу хэрэгтэй вэ?	Хүүхдээ сургуульд оруулахад юу хэрэгтэй вэ?
Аль сургуульд оруульё гэж боддог вэ? Яагаад?	Аль сургуульд оруульё гэж боддог вэ? Яагаад?
Сургуульд буцааж оруулах гэж оролдож байсан уу? Яагаад болоогүй вэ?	Сургуульд оруулах гэж оролдсон уу? Яагаад болоогүй вэ? Та хаана очиж, хэн хэнтэй уулзсан бэ?
Хүүхэд одоо юу хийдэг вэ? Хаана? Өдөрт хэдэн төгрөг олдог вэ? Хэнтэй ажилладаг вэ? Мөнгөө яаж зарцуулдаг вэ? Гэрийнхэндээ, өөр хэн нэгэнд өгдөг бол тэр мөнгийг юунд зарцуулдаг вэ?	Хүүхэд одоо юу хийдэг вэ? Хаана? Өдөрт хэдэн төгрөг олдог вэ? Хэнтэй ажилладаг вэ? Мөнгөө яаж зарцуулдаг вэ? Гэрийнхэндээ, өөр хэн нэгэнд өгдөг бол тэр мөнгийг юунд зарцуулдаг вэ?
Хүү\охин тань хэнтэй нөхөрлөдөг вэ? Тэд	Хүү\охин тань хэнтэй нөхөрлөдөг вэ? Тэд



ямаршуу хүмүүс вэ?	ямаршуу хүмүүс вэ?
Хүүхэд тань сургуульд орьё гэдэг үү\гэж байсан уу?	Хүүхэд тань сургуульд орьё гэдэг үү\гэж байсан уу?
Хүүхэд тань юу хүсч мөрөөддөг вэ? Том болоод ямар хүн болно гэдэг вэ?	Хүүхэд тань юу хүсч мөрөөддөг вэ? Том болоод ямар хүн болно гэдэг вэ?
Хүүхдээ та ямар хүн болоосой гэж хүсдэг вэ?	Хүүхдээ та ямар хүн болоосой гэж хүсдэг вэ?
Ямар ажил хийгээсэй гэж хүсдэг вэ?	Ямар ажил хийгээсэй гэж хүсдэг вэ?
Хаана амьдраасай гэж хүсдэг вэ?	Хаана амьдраасай гэж хүсдэг вэ?

## **2. Хүүхэдтэй ярилцлага хийхэд чиглүүлэх асуултууд**

Сургуульд сурч байсан уу?

<b>Тийм</b>	<b>Үгүй</b>
Хэддүгээр анги төгссөн бэ?	Яагаад сургуульд ороогүй вэ?
Хаана, аль сургуульд сурч байсан бэ?	Сургуульд орьё гэж гэрийнхэндээ хэлж байсан уу? Тийм бол тэд юу гэсэн бэ? Үгүй бол яагаад?
Яагаад сургуулиас гарсан бэ?	
Өөрөө сургуулиас гарахаар шийдсэн үү, гэрийнхэн чинь гаргасан уу? Хэн нь ? Бусад нь яаж хандсан бэ? Чамд юу гэж хэлсэн бэ?	Сургуульд сурах дуртай юу? Яагаад? Уншиж, бичиж чадах уу? Ном уншдаг уу? Хэн зааж өгсөн бэ? Чадахгүй бол сурья гэж боддог уу? Гэрийнхэндээ хэлсэн үү? Тэд юу гэсэн бэ?
Сургуульд ямар дүн авдаг байсан бэ? Ямар хичээлд дуртай, ямар хичээлд дургүй байсан бэ?	Сургуульд сурдаг найзууд бий юу? Сургуульд сурдаг хүүхдүүдтэй яагаад нийлдэггүй вэ?
Сургуульд сурахад юу хамгийн хэцүү байсан бэ?	
Сургуульд сурахад юу нь хамгийн сайхан байсан бэ?	
Ангийн чинь хүүхдүүд ямар байсан бэ? \харьцаа, зан авир\	
Ангидаа найзуудтай байсан уу? сургуулиас гарах гэж байгааг найзууд чинь мэдсэн үү? Юу гэсэн бэ?	
Ангиас чинь олон хүүхэд сургуулиас гарсан уу? Яагаад гарсан бэ? Хүүхдүүд ер нь яагаад сургуулиас гардаг вэ?	
Багш нар чинь ямар байсан бэ?	
Сургуулиас гараад юу хийсэн бэ?	
Сургуульд эргэж орох уу? Хэзээ орох вэ? Яагаад? Сургуульд ороход чамд юу хэрэгтэй вэ?	Сургуульд ороход чамд юу хэрэгтэй вэ?
Аль сургуульд орьё гэж боддог вэ, яагаад?	Аль сургуульд орьё гэж боддог вэ, яагаад?
Сургуульд эргэж орох гэж оролдсон уу? Яагаад болоогүй вэ? Гэрийнхэн чинь юу гэсэн бэ? Чамайг сургуульд оруулах гэж тэд яма нэг зүйл хийсэн үү?	Сургуульд орох гэж оролдсон уу? Яагаад болоогүй вэ? Гэрийнхэн чинь юу гэсэн бэ? Чамайг сургуульд оруулах гэж тэд яма нэг зүйл хийсэн үү?
Чи одоо юу хийдэг вэ? Хаана? Өдөрт хэдэн төгрөг олдог вэ? Хэнтэй ажилладаг вэ? Мөнгөө яаж зарцуулдаг вэ? Гэрийнхэндээ, өөр хэн нэгэнд өгдөг бол тэд тэр мөнгөө яадаг вэ?	Чи одоо юу хийдэг вэ? Хаана? Өдөрт хэдэн төгрөг олдог вэ? Хэнтэй ажилладаг вэ? Мөнгөө яаж зарцуулдаг вэ? Гэрийнхэндээ, өөр хэн нэгэнд өгдөг бол тэд тэр мөнгөө

	яадаг вэ?
Чамд сургуульд явдаггүй найзууд бий юу? Тэд сургуульд орохыг хүсдэг үү? Хүсдэггүй бол яагаад вэ?	Чамд сургуульд явдаггүй найзууд бий юу? Тэд сургуульд орохыг хүсдэг үү? Хүсдэггүй бол яагаад вэ?
Том болоод ямар хүн болно гэж боддог вэ?	Том болоод ямар хүн болно гэж боддог вэ?
Том болоод ямар ажил хийх вэ?	Том болоод ямар ажил хийх вэ?
Том болоод хаана амьдрах вэ?	Том болоод хаана амьдрах вэ?

**Хавсралт 4. “Боловсролын үйлчилгээнд хамрагдалтын байдал” кейс судалгаанд оролцогсдын нэрс, хаяг, судалгааны тэмдэглэл**

*СХД-ийн 3-р хороо 10-р хэсэг*

№	Овог, нэр	Төрсөн он	Нас/хүйс	Гэрийн хаяг	2011 онд давтан судалгаанд орсон байдал
1	Э. Эрдэнэтулга	1993	16/эр	БН-51-8	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуулиас 1-р ангиас завсардсан. Хэл муу дээр нь сурах маш дургүй. Хогийн цэг дээр ажилладаг.
2	Д. Отгонбаяр	1993	16/эр	БН-51-27	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуульд огт сураагүй, хүсдэггүй. Ажил хийж мөнгө олох нь чухал гэж үздэг. Хогийн цэг дээр ажилладаг.
3	Ч. Мөнхзул	1992	17/эм	БН-52-16	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуулиас 2-р ангиас хэл яриа муу гээд завсардсан. Сургуульд оруулах гэж үзсэн боловч том гээд ичээд явах дургүй байдаг. Тогоочоор ажиллаж байгаа.
4	Жаргалсайхан Атарсайхан	1991	18/эр	БН-54-6	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуулиас 1-р ангиас завсардсан. Өөрөө сурах дургүй, ичдэг. Сургуульд яаж оруулахаа мэдэхгүй байна. Хогийн цэг дээр ажилладаг.
5	Таймандай Гульсара	1992	17/эм	БН-54-1	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуулиас 7-р ангиас завсардсан. Монгол хэл мэдэхгүйгээс болоод багш нь ад үзээд хувийн хэргийг нь өөрт нь өгөөд явуулсан байсан. Одоо ичээд сургуульд явах дургүй. Гэртээ байдаг.
6	Г. Мөнхтөр	1994	15/эр	БН-55-41	Судалгаанд хамрагдсан. ИН-29-62 хаяг дээр бүртгэлтэй. Тэр хаяган дээрээ амьдарч байгаа. Сургуулиас завсардсан. Хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүлийн байдлаас болоод сураагүй, гэр бүл нь хүсдэггүй. Гэртээ байдаг.
7	Г. Отгонтөр	1997	12/эр	БН-55-41	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байгаагүй. АБС-д сурч байгаад гарсан, хүсдэггүй Хогийн цэг дээр ажилладаг

8	Г. Мөнхцэцэг	1999	10/эм	БН-55-41	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байгаагүй. Сургуулиас 2-р ангиас завсардсан. Сургуульд явахыг хүсдэг ч багш нар их загнадаг, ад үздэг. Гэртээ байгаа.
9	М. Мөнхбаяр	1998	11/эр	БН-55-31	Судалгаанд хамрагдаагүй. Хороонд бүртгэлгүй, энэ хаягандаа байхгүй нүүсэн.
10	Пүрэв Ганпүрэв	2001	8/эр	БН-55- задгай	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуульд огт сураагүй. Хөдөөнөөс ирээд бичиг баримтгүй, ар гэрийн гачаалаас болсон. Эж нь өвчтэй байсан. Хогийн цэг дээр ажилладаг
11	Даваа Энхзул	2001	8/эм	БН-55-73	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байгаагүй. Замын хажууд урцанд амьдарч байсан. Сургуулиас 1-р ангиас завсардсан, амьдрал хүнд учраас сургуульд сурах хүсэлтэй ч боломжгүй. Хогийн цэг дээр ажилладаг
12	Очирваань Лхагва	1993	16/эм	БН-55-73	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуульд огт сураагүй, хөдөөнөөс шилжүүлэггүй бичиг баримтны зөрчилтэй байсан. Хогийн цэг дээр ажилладаг
13	Хурц Буянжаргал	1995	14/эр	БН-55 задгай	Судалгаанд хамрагдаагүй. Хороонд бүртгэлтэй, хаягандаа байхгүй нүүсэн.
14	Эрхэмбаяр Жавхлан	1994	15/эр	БН-51-3а	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байгаагүй. Хаяггүй газар урцанд амьдарч байсан. Сургуулиас 2-р ангиас завсардсан., явах дургүй, ичдэг. Хогийн цэг дээр ажилладаг
15	Цэндсүрэн	1996	13/эм	БН-54- 35б	Судалгаанд хамрагдаагүй. Хороонд огт бүртгэлтэй, хаягандаа байгаагүй.
16	Түмэнбаяр Чойсүрэн	1994	15/эр	БН-55-57	Судалгаанд хамрагдаагүй. Хороонд бүртгэлгүй, энэ хаягандаа байхгүй нүүсэн
17	Бөөрөнбор Отгонбилэг	1998	11/эм	БН-57-8а	Судалгаанд хамрагдаагүй. Хороонд бүртгэлгүй, энэ хаягандаа байхгүй нүүсэн

*СХД-ийн 4-р хороо 7-р хэсэг*

№	Овог, нэр	Төрсөн он	Нас/ хүйс	Гэрийн хаяг	
18	Энхбаатар Энхбаяр	1995	14/эр	ИН-27-15	Судалгаанд хамрагдсан. Сургуулиас 4-р ангиас завсардсан. Сурах дургүй, чөлөөтэй явах сайхан байдаг учир өөрөө хүсээгүй. Хогийн цэг дээр ажилладаг.
19	Төрбат Наранцэцэг	1992	17/эм	ИН-28 задгай	Судалгаанд хамрагдсан. Төв аймгийн хаягтай, ИН-28-31 хаяг дээр байсан. Сургуулиас 4-р ангиас завсардсан. Гэр бүлийн зүгээс амьдрал хүнд учир

					сургах боломжгүй гэж үздэг. Хогийн цэг дээр ажилладаг
20	Төрбат Нарантуяа	1994	15/эм	ИН-28 задгай	Судалгаанд хамрагдсан. ИН-28-31 хаяг дээр бүртгэлтэй, хаягандаа байсан. Сургуульд огт ороогүй. Гэр бүлийн зүгээс амьдрал хүнд учир сургах боломжгүй гэж үздэг. Хогийн цэг дээр ажилладаг
21	Цолмон Төгөлдөр	1994	15/эр	ИН-28-16	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Сургуульд огт яваагүй. Хагас өнчин, тэжээгчээ алдсаны тэтгэвэрээ авдаг болсон. Ар гэрийн амьдрал хүнд, чөлөөтэй явах дуртай. Хогийн цэг дээр ажилладаг
22	Цолмон Чулуунсүх	1996	13/эр	ИН-28-16	Судалгаанд хамрагдаагүй. Энэ хаяг дээр бүртгэлтэй, хаягандаа байхгүй Найз нь АБС-д явж байгаа гэж хэлсэн.
23	Намжинсүрэн Батсүх	1992	17/эр	ИН-28-20г	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. АБС-д явж байгаа. Хогийн цэг дээр ажилладаг
24	Батсүх Дүүрэнжаргал	1994	15/эм	ИН-29-24	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. 65-р сургуулийн 10-р ангид сурч байгаа. Ээж нь өвчтэй, 6 настай дүүгийн хамт амьдардаг. Хааяа хогийн цэг дээр ажиллаж мөнгө олж ээждээ тусладаг.
25	Гансүрэн Адьяахүү	1993	16/эр	ИН-29-35	Судалгаанд хамрагдсан. Өөр хаягтай шилжүүлэг хийгдээгүй. ИН-28-5 амьдарч байгаа. Сургуулиас 6-р ангиас завсардсан, өөрөө сурах дургүй. Хогийн цэг дээр ажилладаг Аав нь дипод ачигч хийдэг.
26	Доржханд Бямбасүрэн	1995	14/эр	Айлаар хонодог гэргүй	Судалгаанд хамрагдаагүй. Ц. Батцэнгэл болон түүний эгчтэй тэдний гэрт хамт амьдардаг байсан. Хороонд бүртгэлгүй, Налайх ад ажил хийж байгаа гэсэн.
27	Дарханзул Ариунгэрэл		эм	ИН-29-37а	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байсан. Дарханд АБС-д орсон. Танихгүй хүүхдүүдтэй газар сурах нь дээр гэж үзсэн..
28	Цэнд-Аюуш Батцэнгэл	1992	эр	Хаяггүй	Судалгаанд хамрагдсан. ИН-29-5а хаяг дээр бүртгэлтэй. Хаягандаа байгаагүй. Хооллох төв дээр гэрээ барьсан. Бүтэн өнчин, эгчтэйгээ хамт амьдардаг. Сургуульд огт сураагүй, орох бодол байдаггүй. Эгчдээ тусалж амьдралдаа хувь нэмэр оруулах гэж хогийн цэг дээр ажилладаг. Хогийн цэг дээр ажилладаг
29	Жаргалсайхан Нямсүрэн		эм	ИН-29-61	Судалгаанд хамрагдсан. Хаягандаа байгаагүй. БН-55-73 хаяг дээр амьдарч байгаа. Сургуулиас 5-р ангиас завсардсан. Хогийн цэг дээр ажилладаг.

## **2011 оны 3-р сарын 11-нд хийсэн судалгааны дүнг танилцуулах уулзалтын үеэр хүүхдүүд сургуульд явахгүй байгаа талаарх иргэдийн үзэл бодол, санал:**

Хүүхдүүдийг 8, 9 настай байхад нь хүүхдүүд ч юугаа ч мэдэхгүй, эцэг эхчүүд нь ч нэг их санаа зовдоггүй. Тэгээд хэдэн жилийн дараа хүүхдийн нас яваад эхлэхээр эцэг эхүүд ухаан орж санаа нь зовоож эхэлдэг. Тэр үед л яахуу, ихүү гээд ирдэг. Тэгээд л хүүхдүүдээ сургуульд хамруулах гэхэд нас нь явчихсан байдаг тул сургуульд явах гэхэд хүндрэлтэй болдог. Монголчуудад тийм нэг зан байдаг ... Эдний хүүхэд сургуульд явж байхад миний хүүхэд яагаад болохгүй гэж ... эдний хүүхэд хогийн цэг рүү явахгүй байгаа юм чинь би ч гэсэн болчихье доо ... тэгээд хүүхдээ сургуульд оруулах гэсэн хүн ч байна. Одоо ч гэсэн хүүхдээ хайхардаггүй, хариуцлагагүй, ухамсар муутай эцэг эхчүүд байгаа. Хүүхдүүдийг нь сургуульд хамруулах гэхэд өөрсдөө дургүй байх тохиолдол байдаг. Ер нь хүүхдүүд ичдэг гэдэг чинь үнэн. Жишээ нь 2 хүүхэд явж байлаа гэхэд ... Хогийн цэгийн хүүхэд, муухай үнэр танартай ... гэх зэрэг амьдралын боломжгүйгээсээ, гадаад төрх, өмссөн хувцас зэргээс болоод хүүхдүүд нэг нэгнийгээ адалдаг. Тэрийг бас багш нар хүүхдүүддээ ойлгуулах ёстой юм шиг байгаа юм. Албан бусын багш нар бол энэ тал дээр маш сайн ойлголттой. Харин ерөнхий боловсролын сургуулийн багш нар энэ тал дээр маш дутмаг. Таван төгрөг нихээд ирэхэд нь 2, 3 удаа өгөлгүй явуулахад л хүүхдүүдийг багш нар нь адлаад эхэлдэг. Тэгээд л “Би сурах сонирхолгүй” гэдэг яриа тэрнээс л гарсан. Тэрнээс биш яаж ч бодсон сурах дургүй хүүхэд гэж хаа байхав. Хүүхэд болгон найз нөхөдтэйгээ адтлхан байхыг хүсч байгаа.

Хороонд иргэдийн бүхий л асуудлууд хамаатай байдаг болохоор бид иргэдээ бичиг баримтжуулах, хаягтай болгох гээд бүгдэд нь санаа тавьдаг. Жишээ нь манай хөгжлийн нийгмийн ажилтан маань гэхэд л хороонд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүрт ороод л ... Манай хорооны нэг тийм айлын хүүхдийг бичиг баримттай болгоод өгөөч ... гээд л хувийнхаа юмыг гуйж байгаа юм шиг л явдаг. Харин саяны шинэчилсэн бүртгэл, 21000 төгрөг олгогдсон явдал нь иргэдийг бичиг баримттай болгосон ёстой буянтай ажил болсон.

Эдгээр хүүхдүүдийн сургууль завсардалтын асуудлаар манай энэ Нутгийн хөгжлийн төв төрийн бус байгууллагын хийж буй ажлууд нь бидний хийж амжихгүй байгаа ажлуудыг хийж хамтарч ажиллаж байгаа нь үнэхээр сайшаалтай. Төрийн болон ТББ-ууд хамтарсан ажиллагаа энэ дээрээс харагдаж байна гэж боддог. Аль нэг нь санхүүжилт юм уу, завтай завгүйгээрээ ялгарахгүй бүгдээрээ л хамтарч ажиллаж байж л энэ асуудлыг шийдэхээс хороо ганцаараа энэ асуудал дээр хүч хүрэхгүй.

*/СХД-ийн 4-р хорооны 8-р хэсгийн ахлагч Оюунцэцэг/*

Миний охин казак болохоор монгол хэл муу мэднэ. Хичээлээ ойлгохгүй их хэцүү байсан. Уг нь бага ангийн багш нь их сайн эмэгтэй байсан. ... Ямарч байсан чирж байгаад ч гэсэн 4-р ангийг нь төгсгөнө, охин хүүхэд юм чинь... гэдэг байсан. Гэтэл багш нь жирэмсэн болоод чөлөө аваад явахад нь эрэгтэй багш авсан. Тэр эрэгтэй багш их янзын сэтгэлгүй багш байсан. Тэр багш манай охины ангийг аваад 2 сар гаруй болж байхад нэг өдөр охинд минь өөрийнхөн хувийн хэргийг нь бариулаад явуулсан байсан. Уг нь ухаан санаа нь зөв зүгээр. Зөвхөн монгол хэл дээр хичээлээ ойлгохдоо муу хүүхэд байсан. Тэр үед миний бие муу, хавдартай гээд хүүхэддээ анхаарал тавих ч чадалгүй, араас нь нөөцөлдөж явах зав чөлөөтэй хүнгүй хэцүү байсан. Аавд нь хэлсэн боловч ... За яахав дээ тэгэж байгаад болох байлгүй ... гээд өнгөрсөн. Одоо манай хүүхэд 18 нас хүрч байна. Одоо бараг казак хэлээ мартсан. Монголоор их сайн ярьдаг болсон. Сургуульд үргэлжлүүлж сурах гэхээр насан явчихсан хүүхдүүдээс ичдэг. Бид одоо яахаа мэддэггүй.

*/СХД-ийн 3-р хорооны иргэн/*

Хогийн цэг дээр ажиллаж байгаа хүүхдүүдийг яаж ийгээд сургуульд оруулахаар хүүхдүүд нь хогийн цэгийн хүүхдүүд, муухай үнэртэй, муухувцастай гэх зэргээр гадуурхах, мөн хүүхэд л болсон хойно алдаа гаргана тэгэхэд нь ангийн үнэлгээг хойш татлаа гэж багш нар нь уурлан ... Чамайг хэрэггүй ангидаа авч ... гэх зэрэг харьцаа үүсдэг. Ингэхээр чинь ямар хүүхэд сургуульд орохыг бодох вэ? Угаасаа үе тэнгийн хүүхдүүдээс ядуу зүдээгээрээ шоолуулна, дээр нь багш нар нь адлаад байхад хүүхэд байтугай бид ч тэсэхгүй шүү дээ.

*/СХД-ийн 3-р хорооны иргэн П. Явуухүү/*

Миний охин одоо 10-р ангид сурдаг. Сонсгол муутай болохоор их дуу цөөнтэй. Сурлагаараа тийм сайн биш урьдаасаа биш хойноосоо жагсдаг. Ангийнхан хүүхдүүд ч мөн тэгэж ханддаг. Багш нар ч мөн араас нь дугаарлаж ханддаг. Эрүүл хүүхдүүд хоорондоо ингэж байхад сонсгол муу хүүхдийн хувьд бүрч хүндрэлтэй. Энэ талаар сургуулийн багш нартай нь уулзаж хэлэхэд ... Тэгвэл та хүүхдээ тэр тусгай сургуульд нь сургахгүй юу ... гэдэг.

*/СХД-ийн 3-р хорооны иргэн Ц. Цэрэндолгор/*

Хэсгийн ахлагч нартай айлуудаар явж сургуулиас завсардсан хүүхдүүдийн талаар Одоо манай монголын бодлого нь хэт халамж тал руугаа явж байгаа. Жишээ нь сургуулиас завсардсан хүүхдүүд болон хогийн цэг дээр ажиллаж буй хүүхдүүд рүү чиглэсэн Төрийн болон төрийн бус байгууллагуудын төсөл хөтөлбөрийн хүрээнд маш их юм тэдэнд өгдөг. Тийм учраас аль болох тэрнээсээ салахгүйн тулд тэгэж байх нь тэдэнд ашигтай байдаг шиг байгаа юм. Энэ нь эзийн засгийн сонирхол байх. ... Хэрвээ хогийн цэг дээр ажилладаг сургуулиас завсардсан гэвэл ТББ-ууд надад юм олгоно, Илүү халамж дэмжлэг ирнэ ... гэдэгч юм уу. Тэгэхээр гэр бүлийн хандлагыг өөрчлөх хэрэгтэй. Ялангуяа ээжүүдийн хандлагыг өөрчлөх хэрэгтэй. Яагаад гэвэл эмэгтэйчүүд чинь гэр бүлдээ нөлөөлөх нөлөөлөл нь их байдаг учраас. Ихэнхдээ хогийн цэг дээр аав, ээжүүд нь ажилладаг хүүхдүүд байдаг. Энэ нь мөнгөний сонирхол ихтэй гэр бүлийн хүүхдээ хогийн цэг дээр ажиллуулж байгаа юм. Хүүхдүүдтэй тулж ажиллахаас илүү эцэг, эхчүүд, гэр бүл рүү нь тулж ажиллаха нь дээр гэж бодож байна. Хорооноос бичиг баримтжуулах, халамжийн үйлчилгээнд хамруулах, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах ажлуудыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хийдэг.

Сургуулиудын боловсролын нийгмийн ажилтан хороодуудтай хамтарч ажиллах тал дээр ер нь муу байдаг. Мэдээлэл авах гэхээр хаалттай, өгөхгүй. Жишээ нь “Тэгээрэл төв”-ийн боловсролын нийгмийн ажилтнаас өнгөрсөн хавар ... Манай хорооноос хэдэн хүүхэд явж байгаад завсардсан бэ? Нэр ус, хаягийг нь өгөөч ... гэхэд чи тэр хорооныхоо айлуудаар өөрөө яваад тоо баримтаа цуглуулахгүй юу, би чамд өгөхгүй ... гэж байгаа юм чинь. Уг нь бол төрийн байгууллага байтугай иргэдэд хүртэл мэдээлэл нээлттэй байх ёстой шүү дээ.

ЕБС-ийн хүүхдүүдэд эрх зүйн болон зан чанарын сургалтууд ормоор байгаа юм. ЕБС-ын хүүхдүүд АБ-д сурч байгаа хүүхдүүдээ маш их дээрэлхэж, гадуурхдаг гэж байгаа. Тийм учраас АБ-д хүүхдүүд ороод л гарчихдаг. Тэгээд ямар шалтгаанаар чи АБ-аас гарчихваа гэхэд ... Энгийн ангийн хүүхдүүд дандаа шоолж доромжилдог. Хогчдын хүүхэд, хогчдын хүүхэд ... гэдэг. Багш нарт ч тэр, хүүхдүүд ч тэр зан чанарын сургалтууд хийх, эсвэл АББ-ын сургуулийг тусад нь байгуулах хэрэгтэй. Нэг сургууль дээр хамтад нь байлгахаар ийм асуудал яалдаггүй бий болоод байна. Тийм учир АБ-ын хүүхдүүд ороод л 2, 3 сар болоод сургуулиасаа гарчихаад байгаа юм. Сургуулиудын боловсролын нийгмийн ажилтан хороодуудтайгаа хамтран ажиллана гэсэн асуудал байхгүй.

*/СХД-ийн 4-р хорооны нийгмийн ажилтан/*

Яагаад зөрөөтэй тоо гарч байна вэ гэвэл сургууль завсардсан хүүхдийн тоогоор сургуулиудыг байр эзлүүлдэг. Тэгэхээр сургууль тэд нь хүүхэд завсардсан байна гэхээр тэр сургуулийн байр хойшоо ухарнаадаа. Тийм учраас аль болох хэлэхгүй. Аягүй бол сургууль завсардсан хүүхдээ ч тоондоо оруулаад байхыг үгүйсгэхгүй.

Дунд, ахлах ангийн багш нар сургууль завсардаж байгаа хүүдүүдтэй тулж ажилладаггүй. Хүүхэд хогийн цэг рүү явлаа гэхэд эцэг, эх нь хүүхдийнхээ төлөө очиж уулзахгүй бол ангийн багш нэг их явахгүй. Тэгээд л нэг өдөр хүүхдэд өөрт нь хувийн хэргийг нь өгөөд явуулчихна. Тэрний араас сургуулийн нийгмийн ажилтан бараг явахгүй. Би энэ хороонд ажиллаж байхдаа тэгэж явж байсан сургуулийн нийгмийн ажилтан мэдэхгүй юм байна. Харин бага ангийн багш нар л хүүхдүүдтэй тулж ажиллаж байгаа. Тийм учраас тэр сургуулийн тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааг дүгнэхдээ хэдэн хүүхдийг онц гаргасан гэхдээ гол нь биш харин хэдэн хүүхдийг сургуульд хамруулсан тал дээр ажлын үнэлгээг гаргаж ирэх хэрэгтэй. Зөвхөн сургуулийн нийгмийн ажилтны ажлын үнэлгээгээр тэр сургуулийн ажлын үнэлгээг гаргаж ирэх хэрэгтэй.

*/СХД-ийн 4-р хорооны 8-р хэсгийн ахлагч Оюунцэцэг/*